



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ АРГА ХЭРЭГСЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Тайлан I

УЛААНБААТАР ХОТ
2020 он



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ АРГА ХЭРЭГСЛИЙН СУДАЛГААНЫ ШИНЖИЛГЭЭ

ТАЙЛАН

1

УЛААНБААТАР ХОТ
2020 он

Энэхүү тайланг Азийн хөгжлийн банк (АХБ)-ны "Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилгыг Ази-Номхон далайн бүс нутгийн улс орнуудад хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл (ТА-9245)"-ийн хүрээнд Монгол Улсын Үндэсний хөгжлийн газраас эрхлэн боловсруулав.

Уг тайланг мэдлэг олгох болон ашгийн бус зорилгоор бүтэн эсхүл хэсэгчилсэн байдлаар ашиглаж болно. Чингэхдээ зохиогчдоос тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй боловч эх сурвалжийг зайлшгүй дурдах шаардлагатай.

Тайлангийн агуулга, мэдээлэл нь Монгол Улсын Засгийн газрын албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Удирдан чиглүүлж, хянан тохиолдуулсан:

Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Должинсүрэн
Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн С.Сюзанна

Зөвлөхүүд:

Шинжлэх ухааны академийн Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн салбарын дарга,
доктор М.Алтанбагана
Шведийн Вант Улс дахь "Outcome Consulting" ХХК-ийн захирал, доктор Горан Нилсон Ахберг
(Goran Nilsson Axberg)
Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн ахлах эдийн засагч,
магистр Д.Цэнддорж

Хэвлэлд бэлтгэсэн:

Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Р.Сийлэн

Энэхүү тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн Эмма Марсден (АХБ), Тая Концепцион (АХБ), Р.Болор (төслийн үндэсний зохицуулагч) нарт гүн талархал илэрхийлье.

Холбоо барих:

Үндэсний хөгжлийн газар
Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний Гудамж 5/1
Цахим хуудас: www.nda.gov.mn
Утас: 976-51-263333

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. АРГА ХЭРЭГСЭЛД ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД БАРИМТАЛСАН УДИРДАМЖ

- 1.1. Арга хэрэгслийг сонгох шалгуур 7
- 1.2. Арга хэрэгслийн ангилал 8
- 1.3. Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтыг сонгосон байдал . 10

2. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЛЭЖ БУЙ АРГА ХЭРЭГСЛИЙН ТОЙМ

- 2.1. Монгол Улсад хэрэглэж буй арга хэрэгслийн нэгтгэл..... 13
- 2.2. Дүгнэлт 82

3. ОЛОН УЛСАД ХЭВШҮҮЛСЭН АРГА ХЭРЭГСЛИЙН ТОЙМ

- 3.1. Олон улсад хэрэглэж буй арга хэрэгслийн нэгтгэл 83
- 3.2. Дүгнэлт 98

4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ТОВЧИЛСОН ҮГ

АХБ	Азийн хөгжлийн банк
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОБИ	Байгаль орчны бодлогын интеграци
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
МБХ	Монголын банкны холбоо
МТҮП	Мэдээллийн технологийн үндэсний парк
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
СЯ	Сангийн яам
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
МУТХҮБ-2030	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

НҮБ-ын бүх гишүүн орнуудын 2015 онд хамтран «Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр - 2030»-ийг батламжилсан бөгөөд энэ нь хүн төрөлхтний өнөөгийн болон болон ирээдүй хойч үеийн энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх эв санааны нэгдлийн илрэл юм. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2030 он гэхэд дэлхий нийтээр ядуурлыг эцэс болгох, өлсгөлөнг үгүй хийх, эх дэлхийгээ хамгаалах, шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх, тэгш бус байдлыг арилгах, хөгжил цэцэглэлтэд хүрэх 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлт бүхий тогтвортой хөгжлийн төлөөх 17 зорилгыг дэвшүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурал 2016 онд «Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030» (МУТХҮБ-2030)-ыг дээрх 17 зорилготой уялдуулан баталснаар үндэснийхээ урт хугацааны бодлогод Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын үзэл санааг тусгасан анхдагч улс орны нэг болсон төдийгүй ТХЗ-ыг нутагшуулах ажлын эхлэлийг тавьсан юм. Үүний сацуу «Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль» 2016 онд хүчин төгөлдөр болсон нь бодлого төлөвлөлтийн болон институцийн цогц механизмыг хэрэгжүүлэх эрх зүйн орчны үндэс суурийг бүрдүүлсэн түүхэн ач холбогдол бүхий үйл явдал байв.

Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) нь ТХЗ-ыг хөгжлийн бодлогод тусган нутагшуулах ажлыг чиглүүлэх үүрэгтэй Засгийн газрын тохируулагч байгууллага юм. Чингэхдээ ТХЗ хоорондын уялдаа хамаарлыг алдагдуулалгүй, нэгдмэл байдлыг нь хадгалан, хөгжлийн бодлого төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан аливаа бодлогод тусгахыг эрмэлздэг. Үүнийг эш болгон ҮХГ-аас бодлогын уялдаа холбоог үнэлэх матрицад суурилсан арга хэрэгслийг боловсруулж Засгийн газраар батлуулах зэргээр бодлого төлөвлөгчдөд нэн шаардлагатай арга зүй, аргачлалыг боловсруулж, түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал «ТХЗ-ын хэрэгжилтийн Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019»-д систем шинжилгээний аргыг ашиглан хөгжлийн тулгамдсан асуудлын нэг болох агаарын бохирдолд шинжилгээ хийсэн нь салбар дамнасан бусад асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж болохуйц жишиг загвар болсон юм.

Ийнхүү тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч салбарын яам, агентлагууд нь байгаль орчин, эдийн засаг, нийгэм гэсэн хөгжлийн гурван тулгуурыг салангид авч үзэх, уялдаа холбоонд нь бус өөрсдийн хариуцсан асуудал чиг үүргийн хүрээнд салгах нь түгээмэл байна. Үүний нэг илрэл нь байгаль орчны салбарын бодлогын зорилтуудтай уялдаа холбоо сул эдийн засаг, нийгмийн салбарын өнөөгийн бодлогын нөхцөл байдал юм. Тиймээс бодлого боловсруулагчдад зориулан эдийн засаг, нийгмийн салбарын бодлогод байгаль орчинтой холбоотой тогтвортой хөгжлийн зорилгыг уялдуулан тусгах боломжийг бүрдүүлсэн арга хэрэгсэл болон аргачилсан зааврыг боловсруулан хүртээл болгох нь чухал юм.

ҮХГ-аас АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй «Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилгыг Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудад хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх» төслийн хүрээнд байгаль орчинтой холбоотой ТХЗ-ыг нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогыг боловсруулах шатанд нь уялдуулахад ашиглах бодлого, төлөвлөлтийн чанарын

шинжилгээний хялбар арга хэрэгслийг боловсруулахыг зорьсон. Энэ ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж, үр дүнг нь дараах гурван тайланд нийтэллээ.

Тайлан 1. Эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахтай холбоотой арга хэрэгслийн шинжилгээ

Тайлан 2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилгыг тусгахад ашиглах арга хэрэгсэл

Тайлан 3. Салбарын бодлогод тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилгыг тусгасан байдал (Эрүүл мэнд болон эрчим хүчний салбарын бодлогод хийсэн дүн шинжилгээ)

Төслийн хүрээнд боловсруулагдах энэхүү тайлангийн зорилго нь шинээр боловсруулж буй нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилтуудыг байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Үүний зэрэгцээ, арга хэрэгслийн тусламжтайгаар талуудын дунд зөвшилцөл, нэгдсэн ойлголт бий болгох явдал юм.

Тогтвортой хөгжлийн байгаль орчны асуудлыг нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулахад олон улсад болон Монгол Улсад ашигладаг арга хэрэгслийн мэдээллийн баазыг бий болгох нь энэхүү тайлангийн үндсэн зорилго юм.

1. АРГА ХЭРЭГСЭЛД ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД БАРИМТАЛСАН УДИРДАМЖ

1.1. Арга хэрэгслийг сонгох шалгуур

Арга хэрэгслийн тойм судалгааг хийхдээ үндэсний онцлог, эрэлт хэрэгцээнд нийцтэй байх тодорхой шалгууруудыг харгалзан үзсэн.

Олон улсад байгаль орчны асуудлыг байгаль орчны бус салбарын бодлогод тусгах үйл явцад Байгаль орчны бодлогын интеграци (БОБИ) (Environmental Policy Integration)-ийг ашигладаг. БОБИ нь эрчим хүч, хөдөө аж ахуй, дэд бүтэц, эрүүл мэнд зэрэг эдийн засаг, нийгмийн салбарын зорилтуудыг байгаль орчинтой уялдуулах зорилготой. БОБИ-г ашигласнаар салбарын бодлогуудад байгаль орчинтой холбоотой зорилтуудыг тусгахад зөрчил үүсэхээс сэргийлэх ('зохицуулалт'), харилцан эерэг хамаарлыг нэмэгдүүлэх ('уялдаа'), байгаль орчны зорилтуудыг чухалчлах ('эрэмбэ') гээд олон асуудлын харьцааг хангах боломж олддог. (Persson нар., 2018).

БОБИ-ийн нийтлэг шинж чанар:

- а) салбар бүрд болон бүх түвшин дэх байгаль орчныг хамгаалах нийтлэг үүрэг хариуцлага,
- б) байгаль орчныг хамгаалахад чиглэсэн идэвхтэй, урьдчилан сэргийлэх хандлагыг хэрэгжүүлэх замаар байгаль орчинтой холбоотой зорилтуудыг бодлого төлөвлөлтийн шатанд нь уялдуулах,
- в) байгаль орчинтой холбоотой журамд заасан стандартаар хязгаарлагдахгүй байгаль орчны асуудлыг хэрэгжүүлэх.

Дээр дурдсан асуудлуудад үндэслэн арга хэрэгслийг дараах зургаан шалгуурын дагуу шинжилсэн. Үүнд:

1. Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилгын хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн байх,
2. Үндэсний бодлогод байгаль орчны эн тэргүүний асуудлыг тусгахад ашиглах,
3. Бодлого боловсруулах шатанд ашиглах,
4. Байгаль орчны мэргэжлийн бус хүн ашиглах боломжтой, хэрэглэхэд хялбар байх,
5. Байгаль орчны талаарх бүх шатны ойлголтыг дээшлүүлэхэд дэмжлэг болох,
6. Төрийн бус бусад оролцогч талууд хэрэглэх боломжтой байх.

1.2. Арга хэрэгслийн ангилал

Азийн хөгжлийн банк (АХБ, 2019b)-ны тайланд Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилго, зорилтуудыг нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулахад чиглэсэн олон улсын арга хэрэгслүүдийг эмхэтгэн гаргасан байдаг. Тус эмхэтгэл нь дээр дурдсан шалгууруудад нийцтэй арга хэрэгслүүдийг сонгон судлахад чухал эх сурвалж болсон бөгөөд энэхүү тайланд арга хэрэгслийг төрөл, хэрэглээний үе шат, хэрхэн ашиглаж байгаагаар нь ангилан харуулав. Хэрэгслийн төрлийг дараах байдлаар ангилдаг. Үүнд:



Бүтцийн хүрээг бий болгох арга хэрэгсэл (framework tool) нь тэмүүлж буй аливаа үр дүнд хүрэхэд шаардлагатай нэр томьёо, арга механизм, ерөнхий бүтцийг бий болгодог.



Чиглүүлэх арга хэрэгсэл (guidance tool) нь асуудлын хүрээ, арга зүйг тодорхойлох зэрэг бусад төрлийн арга хэрэгслийг өөртөө агуулах боловч аливаа зорилт, үр дүнд хүрэхдээ асуудалд ямар үзэл санаа, арга барилд үндэслэн хандахыг тодорхойлдог арга хэрэгсэл юм.



Арга зүйн арга хэрэгсэл (methodology tool) нь тодорхой дэвшүүлсэн зорилтыг хангахад дагаж мөрдөх арга зүй, үе шат бүхий үйл явцыг агуулсан дараалал байна.



Бие даасан арга хэрэгсэл (standalone tool) нь тодорхой үр дүнд хүрэхэд шаардлагатай арга хэмжээг бусад хэрэгслийн адил өөр хэрэгслүүдийг ашиглахгүйгээр дангаар гүйцэтгэх боломжтой хэрэгсэл байна.

Дээр дурдсан дөрвөн арга хэрэгслийн төрлөөс бүтцийн хүрээг бий болгох арга хэрэгсэл (framework tool) нь зорилтот арга хэрэгслийг сонгох 2-р шалгуурын нөхцөлийг хангаж байгаа учраас авч үзсэн болно.

Бодлого боловсруулан хэрэгжүүлэх үйл явц нь шугаман бус эргэх холбоотой байдаг бөгөөд энэ нь дараа дараагийн бодлогын арга хэмжээг өмнөх арга хэмжээний алдаа дутагдалд үндэслэн сайжрах бололцоог бий болгодог.

АХБ-ны эмхэтгэлд арга хэрэгслийг бодлогын мөчлөгийн үе шат (хэзээ хэрэглэгдэх)-уудад хуваан ангилсан байдаг. Зарим тохиолдолд тухайн арга хэрэгслийг нэг бус зорилгын хүрээнд хэд хэдэн үе шатанд ашиглах боломжтой. Энэхүү төслийн хүрээнд тохиромжтой арга хэрэгслийг сонгохдоо бодлогын мөчлөгийн эхний шат болох асуудлыг тодорхойлж, түүний хамрах хүрээг бий болгох үе шатнаас гадна бодлого боловсруулж, батлуулах шатанд ашиглах арга хэрэгслийг сонгон авч үзлээ.

Зураг 1. Бодлогын мөчлөг



Тайланд Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилтуудыг бодлого, хөтөлбөрт уялдуулан тусгахдаа тухайн арга хэрэгслийг ямар байдлаар ашиглаж байгаагаар нь мөн ангилсан байдаг.



Стратегийн арга хэрэгсэл (strategic tool) нь байгаль орчны зорилтыг бодлогын баримт бичигт тусгах болон бодлого хоорондын уялдаа холбоог сайжруулахад тустай хэрэгсэл юм.



Процессын арга хэрэгсэл (procedural tools) Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудыг бодлогын мөчлөгийн хэрэгжүүлэх үйл явцад ашиглахад хамгийн үр дүнтэй гэж үздэг.



Зохион байгуулалтын арга хэрэгсэл (organizational tool) нь өөрчлөлт, шинэчлэлийн шинж чанартай бөгөөд засаглал, институцийн механизм болон ажил үүргийн хуваарилалтын чиглэлийн өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхэд ашигладаг. Энэ арга хэрэгслийг ашиглах явцад төр болон бусад талуудын оролцоо, хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай болно.


Энэ хэсгээс **стратегийн арга хэрэгсэл** нь шалгуур 1, 2, 4 ба 6-г хангаж байгаа тул цаашид сонгон авч үзэв.

1.3. Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтыг сонгосон байдал

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны эмхэтгэлд ТХЗ 6 (Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах), ТХЗ 12 (Хариуцлагатай хэрэглээг дэмжих), ТХЗ 15 (Хуурай газрын эко системийг хамгаалах)-ын зорилтуудад чиглэгдсэн арга хэрэгслийг хамааруулан авч үзсэн байна. Эдгээр зорилгууд нь бүгд байгаль орчны асуудлыг хамарч байгаа бөгөөд Монгол Улсад хэрэгжих арга хэрэгсэлд тусгалаа олсон байх шаардлагатай юм.





Тогтвортой хөгжлийн 6, 12, 15 дугаар зорилгын зорилтуудаас гадна Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой, байгаль орчны асуудалтай холбоотой гэж үзсэн **нэмэлт 19 зорилтоор байгаль орчинд холбогдолтой үзүүлэлтүүдийн хамрах хүрээг өргөтгөн тодорхойлж**, бодлогын шинжилгээ хийх арга хэрэгсэлд ашиглахаар сонгон авсан. Хэдийгээр ТХЗ 14 нь далайд гарцгүй орны хувьд манайд шууд хамааралгүй боловч загасчлалтай холбоотой зорилтыг энэ тайланд хамааруулан авч үзсэн.

Зураг 2. Сонгон авсан ТХЗ-ын байгаль орчинтой холбоотой зорилгын зорилтын тоо



Тогтвортой хөгжлийн нийт 12 зорилгын хүрээнд 48 зорилгыг сонгон авсан бөгөөд үүнд ТХЗ 6, 12, 15 хамаарна. Үүнээс гадна нэмэлтээр сонгон авсан 19 зорилгыг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (МУТХҮБ-2030), Ногоон хөгжлийн бодлого болон бусад үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан сонгосон болно. Нэмэлтээр авсан 19 зорилгыг АХБ (2019а)-ны тайланд орсон тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилтуудтай харьцуулсныг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Нэмэлтээр сонгон авсан тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой 19 зорилгыг АХБ(2019а) тайлан, МУТХҮБ-2030, Ногоон хөгжлийн бодлоготой харьцуулсан байдал

				
#	ТХЗ-ын зорилт	АХБ (2019а)	МУТХҮБ-2030-ын зорилт	Ногоон хөгжлийн бодлогын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ
1	2.4	+	2.1.1 Зорилт 1	3.1.4
2	2.5	+		3.2.5
3	3.9	+		3.1.10, 3.2.12, 3.6.2
4	4.7		2.2.3 Зорилт 4	3.5.1
5	7.1		2.1.5 Зорилт 1	
6	7.2	+	2.1.5 Зорилт 2	3.1.1
7	7.3	+		3.1.1
8	8.4	+	2.3.2 Зорилт 2	3.1.3, 3.1.9, 3.1.12 3.2.12, 3.3.2, 3.3.4
9	8.9	+	2.1.2 Зорилт 1	3.1.7, 3.2.2
10	9.4	+	2.1.4 Зорилт 2	3.1.12, 3.6.2
11	11.3		2.3.3 Зорилт 2	3.6.1
12	11.4	+	2.1.2 Зорилт 1	3.2.2
13	11.6	+	2.1.5 Зорилт 6	3.6.2
14	11.7	+	2.3.3 Зорилт 2	3.6.3
15	11.A	+	2.1.5 Зорилт 6	3.6.2
16	11.B	+	2.1.5 Зорилт 6	3.6.1
17	13.1		2.3.2 Зорилт 2	
18	13.3		2.2.3 Зорилт 4	3.5.1
19	14.4	+		

2. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЛЭЖ БУЙ АРГА ХЭРЭГСЛИЙН ТОЙМ

2.1. Монгол Улсад хэрэглэж буй арга хэрэгслийн нэгтгэл

Тайлангийн энэ хэсэгт байгаль орчны асуудалтай холбоотой Монгол Улсад хэрэглэж буй арга хэрэгслүүдийг дээрх бүлэгт харуулсан төрөл, хэрэглэх үе шат, зориулалтаар нь ангилсны дагуу нэгтгэн харууллаа. Ингэхдээ хариуцах байгууллага болон арга хэрэгслийн аль ТХЗ, зорилтуудад хамаарч хэрэгжиж байгааг мөн харуулсан. Үүний өмнө төрийн байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээнүүдийг дурдах нь зүйтэй.

Эрчим хүчний яам одоо ажиллаж байгаа цахилгаан станцуудын үр ашгийг дээшлүүлэхийн сацуу нар, салхи, усан цахилгаан станц зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох чиглэлээр ажиллаж байна. “Ухаалаг эрчим хүч-2019” санаачилгын хүрээнд хэрэглэгчид болон нийлүүлэгчийн аль алинд нь автоматжуулалтаар дамжуулан үр ашгийг дээшлүүлэх асуудлыг шийдэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Түүнчлэн байгаль орчны асуудалтай шууд холбоотой өөр нэг асуудал болох агаарын бохирдлыг бууруулах зорилгоор олон улсад түгээмэл ашиглагддаг шахмал түлшийг зах зээлд нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Барилга, хот байгуулалтын яамнаас барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийг хөгжүүлсэн. Барилгын салбарт эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах “НАМА” төсөл нь Монгол Улсын барилгын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний онцлогт тохирсон арга хэмжээг тодорхойлон, хэрэгжүүлэх замаар, барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй технологийн хэрэглээг нэмэгдүүлэх, зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь газар тариалангийн болон бэлчээрийн зориулалттай талбайг тодорхойлох арга зүйн хэрэгслийг ашиглаж байгаа бол цаашид хохирол учирсан талбайн үнэлгээг гаргах чиглэлд арга зүйг нарийвчлан боловсруулахаар ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яам нь “Монгол орны зам, цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийн чадавхыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд зам хучилтын стандартыг сайжруулах чиглэлээр ажиллаж байна. Үүнээс гадна «Таван толгой-Гашуун сухайт»-ын чиглэлд нүүрсийг чингэлэгт тээвэрлэх ажил хэрэгжиж байна. Ингэснээр тээвэрлэлтийн явцад үүсдэг нүүрсний алдагдлыг бууруулж, нүүрсийг терминал дээр дахин ачаалсны улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах юм. Мөн МОН-30 маркийн хоёр цахилгаан автобусыг үйлдвэрлэж нийтийн тээвэрт нэвтрүүлэх туршилтын ажлууд хийгдэж байна.

Тайлан боловсруулах явцад хийсэн ярилцлага болон Засгийн газраас баталсан дүрэм, журмуудад хийсэн судалгааны үр дүнг дүгнэж үзэхэд яам, агентлагуудын түвшинд хэрэглэдэг, үндэсний түвшинд хэвшүүлсэн, байгаль орчны асуудлыг хамарсан арга хэрэгслийг нэгтгэн Хүснэгт 2-т харуулав. Чингэхдээ арга хэрэгсэл бүрийг хариуцсан байгууллага, түүнд хамааралтай ТХЗ-ын зорилтуудыг тодорхойлсон. Арга хэрэгслийг ангилахдаа АХБ-ны ангиллыг ашигласан бөгөөд хоёр дахь мөрний кодлох хэсэгт бага зэрэг өөрчлөлт хийв. Код нь Монгол Улсын буюу "М" үсгээр эхэлсэн, ТХЗ-ыг нийтэд нь авч үзсэн бол "G", байгаль орчны олон зорилгыг хамарсан бол "E", ТХЗ 15-д чиглэсэн бол "D" үсгээр тус тус тэмдэглэсэн болно. "O" үсэг нь бусад (ангилахад төвөгтэй гэх мэт), ТХЗ 6-г хамарсан бол "W", ТХЗ 12-ийг хамарсан бол "R" үсгээр тэмдэглэсэн. Албан ёсны эсвэл томоохон итгэмжлэгдсэн байгууллагаас гаргасан журам, удирдамж, норм, стандарт, аргачлал зэрэг нь энэхүү тоймд багтав.

■ ТХЗ-ыг нийтэд нь хамарсан

■ Байгаль орчны ТХЗ-ыг ерөнхийд нь хамарсан

■ ТХЗ 14, 15

■ ТХЗ 15

■ ТХЗ 6

■ ТХЗ 12




Хүснэгт 2. Үндэсний түвшинд хэвшүүлсэн арга хэрэгслүүд

#	Код	Арга/Хэрэгслийн нэр	ТХЗ-ын зорилт	Хариуцах байгууллага	Төрөл				Хэрэглэх үе шат				Хэрхэн хэрэглэх				
					Бүтцийн хүрээг бий болгох хэрэгсэл (framework tool)	Чиглүүлэх хэрэгсэл (guidance tool)	Арга зүйн (процесс)-ийн хэрэгсэл (methodology tool)	Бие даасан хэрэгсэл (standalone tool)	Асуудал, хамрах хүрээг тодорхойлох (issue identification and framing)	Боловсруулж, батлуулах (formulation and drafting)	Хэрэгжүүлэх (implementation)	Хяналт, үнэлгээ хийх (monitoring, evaluating and reporting)	Стратегийн хэрэгсэл (strategic tool)	Процессын хэрэгсэл (procedural tool)	Зохион байгуулалтын хэрэгсэл (organizational tool)		
1	MG1	Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, түүнийг тооцох аргачлал	6.1, 6.2, ТХЗ 15	ҮСХ													
2	MG2	Систем шинжилгээ (Systems Analysis)	Нийт ТХЗ	ҮХГ													
3	MG3	ТХЗ-ын тогтолцооны нөхцөл байдлын шинжилгээ (ICA)	Нийт ТХЗ	ҮХГ													
4	MG4	Тогтвортой хөгжлийн бодлогын загварчлал (Modeling Tools for Sustainable Development Policies)	ТХЗ 6, ТХЗ 7, ТХЗ 13	ҮХГ													
5	MG5	Тогтвортой хөгжлийн хяналтын самбар (Sustainability Dashboard)	Нийт ТХЗ	ҮСХ													
6	MG6	ТХЗ-ын харилцан хамаарлын ерөнхий бүрдүүвч (SDG Interactions Framework)	Нийт ТХЗ	ҮХГ													
7	MG7	Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам	Нийт ТХЗ	Төрийн захиргааны байгууллагууд													
8	ME1	Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам	9.4, 9.b, 12.2	БОАЖЯ													




36	MD7	Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам	15.4, 15.7, 15.8	БОАЖЯ, Аймгийн Засаг дарга нар															
37	MD8	Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам	15.4, 15.7, 15.8	БОАЖЯ, Аймгийн Засаг дарга нар															
38	MD9	Ан амьтан, тэдгээрийн гэрэлтэй түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт олгох, хяналт тавих журам	15.4, 15.7, 15.8	БОАЖЯ															
39	MD10	Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам	12.2, 15.7, 15.8	МХЕГ															
40	MD11	Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам	15.4, 15.7, 15.8	МХЕГ															
41	MD12	Ургамлын нөхөн төлбөрийг төлүүлэх журам, арга-члал	15.7, 15.а	БОАЖЯ															
42	MO1	Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам	13.1	ОБЕГ															
43	MO2	"Монгол инновац" - Бодлогын зөвлөмж	8.2, 8.3, 9.б, 9.5	MTUP-ын Инкубатор, бизнес хөгжүүлэлтийн төвөөс гаргасан зөвлөмж															
44	MW1	Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ	6.4, 6.6, 15.1	СЯ, БОАЖЯ, ЭМЯ, МХЕГ, Аймаг, нийслэлийн Засаг дарга															
45	MW2	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм	6.4, 6.6	БОАЖЯ, ЭМЯ															
46	MW3	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам	6.3	БОАЖЯ															
47	MW4	Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны менежментийн журам	6.5, 15.3	Сав газрын захиргаа, Бүх шатны Засаг дарга нар															
48	MW5	Унд ахуйн зориулалттай усны объектын усны чанарын норм, шаардлага	6.2	БОАЖЯ, ЭМЯ, ХНХЯ															

Энэ хэсэгт Хүснэгт 2-т заасан арга хэрэгсэл тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулав. Тухайн арга хэрэгслийг баталж, нийтэлсэн байгууллагын нэр болон батлагдсан огноог эх сурвалж бүхий холбоосын хамт харуулав.

Дугаар 1

ТАЙЛБАР	
Нэр:	Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, түүнийг тооцох аргачлал
Үндсэн агуулга ба зорилго:	Монгол Улс ногоон хөгжлийн бодлогыг томъёолж, улмаар ногоон хөгжлийн үзүүлэлтүүдийг тодорхойлох, тооцох аргачлалыг олон улсын арга зүйд нийцүүлэн боловсруулах, үзүүлэлтийн системийг бий болгох ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд ногоон эдийн засаг/хөгжлийг тодорхойлох, цаашилбал, ногоон хөгжлийн загварт шилжих зөв зохистой арга хэрэгсэл, ногоон хөгжлийн үе шатыг үнэлэх, хүрэх түвшинг тодорхойлох боломж бүрдсэн.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2017 оны 7 дугаар сарын 3-ны өдөр
Баталсан субъект:	ҮСХ-ны даргын А/103 дугаар тушаал
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	http://sdg.gov.mn/Content/files/green_dev_methodology.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.1, 6.2, ТХЗ 15
Ангиллын код:	MG1
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 2

ТАЙЛБАР	
Нэр:	Систем шинжилгээ (Systems Analysis)
Үндсэн агуулга ба зорилго:	Системийн шинжилгээ нь тухайн системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоо, харилцан үйлчлэлийг авч үздэг бөгөөд нарийн төвөгтэй системийг цогц байдлаар шийдвэрлэхэд чиглэсэн арга юм. Энэ төрлийн арга хэрэгсэлд хугацааны цуваан график, учир шалтгааны эргэх холбооны диаграм, хуримтлагдсан болон урсгал өөрчлөлтийн диаграм, мөсөн уулын загвар мөн динамик загварууд орно.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2018
Баталсан субъект:	Үндэсний хөгжлийн газар
Төрөл:	Загварчлал
Эх сурвалж:	http://www.systems-thinking.org/stada/stada.htm
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	Нийт ТХЗ
Ангиллын код:	MG2
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	






Дугаар 3

ТАЙЛБАР	
Нэр:	ТХЗ-ын тогтолцооны нөхцөл байдлын шинжилгээ (ICA)
Үндсэн агуулга ба зорилго:	Энэхүү арга хэрэгслийг ТХЗ-ын хэрэгжилтийг сайжруулах эсвэл бодлогыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг даван туулахад туслах элементүүдийг тодорхойлоход хэрэглэдэг. Энэхүү хэрэгсэл нь хууль тогтоомж, дүрэм журам (эсвэл онолын хувьд хэрхэн ажиллах ёстой) мэт албан ёсны дүрэм болон албан бус (практик дээр яаж ажилладаг вэ) нөхцөл байдлын хоорондын зөрүү (gap), түүний шалтгааныг олж тогтооход тусалдаг. Түүний дараагаар олон улс, үндэстэн доторх, орон нутгийн түвшин дэх тухайн асуудалд чиглэсэн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц янз бүрийн оролцогч талууд, тэдний үйл ажиллагаа, ашиг сонирхлыг авч үздэг.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2016
Баталсан субъект:	Үндэсний хөгжлийн газар
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://www.alnap.org/system/files/content/resource/files/main/Institutional_and_Context_Analysis_August_2017.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	Нийт ТХЗ
Ангиллын код:	MG3
- Төрөл:	 
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	  






Дугаар 4

ТАЙЛБАР	
Нэр:	Тогтвортой хөгжлийн бодлогын загварчлал (Modeling Tools for Sustainable Development Policies)
Үндсэн агуулга ба зорилго:	MAMS загварт үндэсний нийгмийн тооцооллын матрицыг ашиглан тухайн улсын нөхцөлд тохируулан боловсруулж бодлогын хувилбаруудын хувьд төсөөлөл гаргадаг. Энэ арга хэрэгсэлд шатахууны татварын өөрчлөлт; эрчим хүчний системийн дүн шинжилгээ; уур амьсгал, газар, эрчим хүч, усны системийн (CLEWS) дүн шинжилгээг хийж болдог.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	
Баталсан субъект:	Үндэсний хөгжлийн газраас судалж байгаа
Төрөл:	Загварчлал
Эх сурвалж:	https://un-modelling.github.io/
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	TX3 6, TX3 7, TX3 13, TX3 15
Ангиллын код:	MG4
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	






Дугаар 5

ТАЙЛБАР	
Нэр:	Тогтвортой хөгжлийн хяналтын самбар (Sustainability Dashboard)
Үндсэн агуулга ба зорилго:	Олон төрлийн Тогтвортой хөгжлийн хянах самбарууд байдаг ч эдгээр нь голдуу тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг нээлттэй, шуурхай байршуулдаг веб сайтууд юм. Тиймээс тухайн үзүүлэлтийн чиг хандлагын талаарх мэдээллийг бүс нутгийн болон үндэсний түвшинд холбогдох байгууллагууд хэрэглэгчдэд шууд нэгтгэн тайлагнах боломжийг олгодог.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2018
Баталсан субъект:	ҮСХ-нд хэрэгжсэн
Төрөл:	Тайлан
Эх сурвалж:	http://www.sdgdashboard.org/
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	Нийт ТХЗ
Ангиллын код:	MG5
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	 
- Хэрэглээ:	 




Дугаар 6

ТАЙЛБАР	
Нэр:	ТХЗ-ын харилцан хамаарлын ерөнхий бүдүүвч (SDG Interactions Framework)
Үндсэн агуулга ба зорилго:	Энэхүү хэрэгсэл нь ТХЗ-ын хэрэгжилтэд чиглэсэн үйл ажиллагааны харилцан хамаарал, шалтгааныг тогтоож оноожуулах аргачлал юм. Ийнхүү үйл явцын харилцааг системтэй үнэлэх нь салбар хоорондын уялдаа холбоог хангах, нөөц ашиглалтын үр дүнтэй хувилбаруудыг тодорхойлох, зорилтот кластер бүлгүүдийн зураглалыг харуулахад тусалдаг. Монгол Улсад энэ арга хэрэгслийг МУТХҮБ-2030-д дүн шинжилгээ хийж ашигласан байдаг.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2019
Баталсан субъект:	ҮХГ хэрэгжсэн
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://www.sei.org/wp-content/uploads/2019/07/sei-2019-sdg-synergies-mongolia.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	Нийт ТХЗ
Ангиллын код:	MG6
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	 
- Хэрэглээ:	 





Дугаар 7

ТАЙЛБАР	
Нэр:	Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам
Үндсэн агуулга ба зорилго:	Төрийн захиргааны төв болон Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4.1-6.4.3, 6.5.1, 6.5.2-т заасан урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулахтай холбогдсон нийтлэг харилцааг энэхүү журмаар зохицуулна.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2016 оны 5 дугаар сарын 9-ний өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 249 дүгээр тогтоолын хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/7310?law-id=11962
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	Нийт TX3
Ангиллын код:	MG7
- Төрөл:	 
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	 




Дугаар 8

ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам
Үндсэн агуулга ба зорилго:	Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах, эрчим хүчийг хэмнэх, хүлэмжийн хийн ялгарал, хог хаягдал болон дулаан алдагдлыг багасгах, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж урамшуулах, "Ногоон гэрчилгээ" болон "Эко тэмдэг" олгох харилцааг зохицуулахад оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 290 дүгээр тогтоол
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/8053?lawid=12908
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	9.4, 9.b, 12.2
Ангиллын код:	ME1
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 9

ТАЙЛБАР	
Нэр:	Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТОС)-ийн зарчмууд, удирдамж
Үндсэн агуулга ба зорилго:	Банкнууд үйл ажиллагаа явуулж, бизнесийн шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгмийн асуудлыг харгалзан авч үзэхэд баримтлах зарчмыг боловсруулан, хэрэгжүүлж байна. Энэ нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, багасгах, бий болохоос зайлсхийхийг эрмэлзэх, түүнчлэн улс орны ногоон эдийн засгийн өсөлт, хөгжлийн зорилгод нийцсэн төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэхийг дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийн олон талт хөгжилд хувь нэмэр оруулах Тогтвортой санхүүжилт (ТОС)-ийг бий болгох нэг арга зам юм.
Хамрах хүрээ:	Банкны салбар
Батлагдсан огноо:	2014 он
Баталсан субъект:	Монголын банкны холбоо
Төрөл:	Удирдамж, зөвлөмж
Эх сурвалж:	http://toc.mn/ufiles/uploaded/files/1534411217134.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	9.3
Ангиллын код:	ME2
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	 




Дугаар 10

ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
Үндсэн агуулга ба зорилго:	Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 дугаар тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/10262?lawid=14757
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.6, 15.1, 12.2, 12.8
Ангиллын код:	МЕЗ
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 11





ТАЙЛБАР	
Нэр:	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж
Үндсэн агуулга ба зорилго:	ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг тухайн тусгай хамгаалалттай газар дахь хамгаалах үнэт зүйлсийг тодорхойлон, өнөөгийн төлөв байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, тэдгээрт учирч буй болон ирээдүйд учирч болох аюул, дарамтад дүн шинжилгээ хийсний үндсэнд алсын хараа, эрхэм зорилго, зорилтоо тодорхойлон, дэвшүүлсэн зорилтуудаа хэрэгжүүлэхэд чиглэгдсэн тодорхой хугацааг хамарсан, оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн, эрх бүхий байгууллагаар баталгаажсан, өөрөөр хэлбэл тусгай хамгаалалтад авсан газрыг өнөө болон ирээдүйд хэрхэн, яаж удирдан зохион байгуулах чиг зүгийг заасан "луужин" гэж ойлгож болно.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2012 он
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрөл:	Зөвлөмж
Эх сурвалж:	http://cmp-openstandards.org/wp-content/uploads/2016/06/Open-Standards-Mongolian-2012.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.6, 15.1, 15.4, 15.5
Ангиллын код:	ME4
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
Хэрэглээ:	





Дугаар 12

ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам
Үндсэн агуулга ба зорилго:	Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт заасан төлбөрийн орлогыг (байгалийн ургамал, ус, рашаан, ой, амьтны нөөц, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах) бүрдүүлэх, төсвийн зарлагад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн тусгах, зарцуулах, тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2014 оны 2 дугаар сарын 14-ний өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 43 дугаар тогтоол
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/6215?lawid=9794
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.a, 15.b
Ангиллын код:	ME5
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	






Дугаар 13

ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал
Үндсэн агуулга ба зорилго:	Байгалийн нөөц баялгийг ашиглах аливаа үйл ажиллагааны улмаас байгаль орчин буюу байгалийн нөөц баялаг, ус, хөрс, ургамал, ой, зэрлэг ан амьтан, тэдгээрийн төрөл зүйлийн амьдрах орчинд учирсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, экологийн хохирлыг тооцох ажлыг зохион байгуулахад уг аргачлалыг ашиглана.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2010 оны 5 дугаар сарын 27-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-156 дугаар тушаал
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/5430?lawid=7513
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.a, 15.b
Ангиллын код:	ME6
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал
Үндсэн агуулга ба зорилго:	Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших жилүүдэд байгалийн нөөц баялгийг эмх замбараагүй ашигласнаар байгаль орчны бохирдол, доройтол, байгалийн нөөц баялгийн хомсдол үүсэж, бохирдлыг бууруулах, байгаль орчныг сэргээхэд асар их хэмжээний хөрөнгө, хүч шаардлагатай болж байна. Иймээс аливаа төсөл хэрэгжүүлэгч нь шинээр барилга байгууламж барих, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, үйл ажиллагаа явуулахдаа юуны өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх шаардлагатай. Ингэснээр байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлах, байгалийн нөөц баялаг бохирдох, хомсдохоос сэргийлэх, төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлэх, экологи-эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсөл хэрэгжүүлэгчийг болзошгүй алдагдал, хохирлоос сэргийлэх, тухайн төслөөс хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тогтоож, түүнийг бууруулах болон арилгах арга хэмжээг бодитой төлөвлөн хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдэнэ.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд, үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагууд
Батлагдсан огноо:	2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-117 дугаар тушаал
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/2014.7.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.6, 12.2, 15.1, 15.5
Ангиллын код:	ME7
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	 

ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчны менежментийг сайжруулах аргачилсан зөвлөмж
Үндсэн агуулга ба зорилго:	“Байгаль орчны менежментийн чадавхыг үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах” төсөл нь байгаль орчны болон байгалийн нөөцийн менежментийн хэрэгцээг үнэлэхэд төрийн байгууллагын чадварыг сайжруулах; байгаль орчны чиглэлээр мөрдөж буй хууль эрх зүйн баримт бичиг, байгаль орчны үнэлгээний чадавхыг сайжруулах; байгаль орчны болон байгалийн нөөцийн менежментийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх гэсэн хоорондоо уялдаа бүхий гурван зорилготой.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2006 он
Баталсан субъект:	Дэлхийн банкны “Байгаль орчны менежментийн чадавхыг үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх нь” IDF Grant TF 051255 төслийн хүрээнд санал болгосон аргачилсан зөвлөмж
Төрөл:	Аргачилсан зөвлөмж
Эх сурвалж:	http://siteresources.worldbank.org/MONGOLIAINMONGOLIANEXTN/Resources/Manual_4_Env_Mgmt_MON.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.b, 12.2, 12.4, 12.c
Ангиллын код:	ME8
- Төрөл:	 
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	

Дугаар 16

ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам
Үндсэн агуулга ба зорилго:	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-03 тоот тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/6169?law-id=9746
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.6, 6.b, 15.1, 15.5
Ангиллын код:	ME9
- Төрөл:	 
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	 



Дугаар 17




ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам
Үндсэн агуулга ба зорилго:	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, түүнтэй холбогдсон шийдвэр гаргах, оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/6137?lawid=9681
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	12.2, 15.1, 15.5
Ангиллын код:	ME10
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	

Дугаар 18






ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам
Үндсэн агуулга ба зорилго:	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.3.-д зааснаар “байгаль орчны стратегийн үнэлгээ” гэж улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, байгалийн гамшигт үзэгдэлтэй уялдуулан тодорхойлох үндсэн зорилготой үйл явц юм.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/6137?law-id=9681
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.6, 12.2, 15.1, 15.5
Ангиллын код:	ME11
- Төрөл :	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ :	

Дугаар 19








ТАЙЛБАР	
Нэр:	Шүүлтүүрийн шинжилгээний аргачлал (filtration analysis)
Үндсэн агуулга ба зорилго:	Энэхүү аргачлал нь үндэсний, салбарын, аймаг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, төлөвлөлт, төсөвлөлтийн баримт бичгүүдэд Монголын нөхцөлд тодорхойлсон Ногоон хөгжлийн үзүүлэлтээр чанарын шинжилгээ хийхэд оршино.
Хамрах хүрээ:	Бүс нутаг, аймаг, сум
Батлагдсан огноо:	2015 он
Баталсан субъект:	Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны захиалгаар Үндэсний хөгжлийн хүрээлэнгээс хэрэгжүүлсэн "Ногоон хөгжлийн тэргүүлэх 5 аймгийн сумдын байгаль орчин, нийгмийн эмзэг байдлын судалгаа хийж, бодлогын санал зөвлөмж боловсруулах" төслийн хүрээнд боловсруулсан.
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	М.Алтанбагана, Б.Хэрлэнбаяр, Б.Сувданцэцэг, Х.Номинболор. 2015. "Ногоон хөгжлийн тэргүүлэх 5 аймгийн сумдын байгаль орчин, нийгмийн эмзэг байдлын судалгаа хийж, бодлогын санал зөвлөмж боловсруулах" бодлогын судалгааны тайлан. Үндэсний хөгжлийн хүрээлэн. Улаанбаатар хот. М.Алтанбагана, Б.Сувданцэцэг, Т.Чулуун, Х.Номинболор, Б.Хэрлэнбаяр. 2015. "Эмзэг байдлын үнэлгээнд тулгуурлан Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх нь". Монгол орны бэлчээрийн сэргэн хөгжих чадавхыг бэхжүүлэх нь сэдэвт салбар хөрвөсөн олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар хот.
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.6, 12.2, 15.1, 15.5
Ангиллын код:	ME12
- Төрөл :	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ :	






ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчны статистикийг хөгжүүлэх үндсэн хүрээ (FDES)
Үндсэн агуулга ба зорилго:	Байгаль орчны статистикийг хөгжүүлэх үндсэн хүрээ (FDES 2013) (2017) нь байгаль орчны статистик мэдээллийг улсын хэмжээнд цуглуулах, нэгтгэх, бүрдүүлэх чиглэлийг өгдөг. Байгаль орчны статистик мэдээллийг цуглуулж нэгтгэн боловсруулснаар бодлогын мөчлөгийн бүх үе шатыг мэдээлж болно. Гэхдээ FDES 2013-ын гол зорилго нь байгаль орчны статистик хөтөлбөр боловсруулах эхний шатан дахь улс орнуудад тусламж, гарын авлага болох юм. Олон улс орнууд байгаль орчны статистикийн мэдээллийн сан, нэгтгэлийг бий болгохдоо энэ бүтцийг ашиглаж байна.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2018
Баталсан субъект:	Үндэсний статистикийн хороонд хэрэгжсэн
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://unstats.un.org/unsd/environment/FDES/FDES-2015-supporting-tools/FDES.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	Байгаль орчинтой холбоотой ТХЗ
Ангиллын код:	ME13
- Төрөл :	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ :	

Дугаар 21




ТАЙЛБАР	
Нэр:	Байгаль орчин, эдийн засгийн данс (SEEA)
Үндсэн агуулга ба зорилго:	SEEA нь байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эдийн засагт оруулсан хувь нэмэр, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хэмжих эдийн засаг, байгаль орчны цогц тооцооллыг нэгтгэсэн аргазүйн баримт бичиг юм. Энэ арга хэрэгсэлд улс орны эдийн засаг, байгаль орчны хоорондын харилцан холбоог илэрхийлж, байгалийн хөрөнгийн нөөц, түүний өөрчлөлтүүдийн тайлбарыг багтсан. Энэ нь байгаль орчны үзүүлэлтүүдийг нэгтгэх, тэдгээр үзүүлэлтүүд болон эдийн засгийн хоорондын уялдаа хамаарлыг үндэсний статистикийн хөтөлбөрт тусгахад тусална.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2018
Баталсан субъект:	Үндэсний статистикийн хороо
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	http://1212.mn/stat.aspx?LIST_ID=976_976_L31
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	Байгаль орчинтой холбоотой ТХЗ
Ангиллын код:	ME14
- Төрөл :	 
- Хэрэглээний үе шат:	 
- Хэрэглээ :	

Дугаар 22




ТАЙЛБАР	
Нэр:	ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төсөв болон хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөний арга хэрэгсэл (Integrated Planning, Budgeting, and Investment Tools for Achieving the SDGs)
Үндсэн агуулга ба зорилго:	ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төсөв болон хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөний арга хэрэгсэл: Ази, Номхон далайн бүсийн хамтын ажиллагааны хөтөлбөр (2017) нь Ази, Номхон Далайн орнуудын урт хугацааны хамтын ажиллагаагаар эхлүүлэн боловсруулсан 60 голлох арга хэрэгсэл, аргачлалыг нэгтгэсэн байдаг. Үүнд тогтвортой хөгжлийн зорилтуудыг төрийн болон хувийн хэвшлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, мэдээллийн системд уялдуулан нэгтгэх арга хэрэгслүүдийг багтаасан болно.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2019
Баталсан субъект:	Сангийн яаманд хэрэгжсэн
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://www.unpei.org/system/files_force/PEI%20AT%20Compendium%20%28refined_2%29%20%281%29.pdf?download=1
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	Байгаль орчинтой холбоотой ТХЗ
Ангиллын код:	ME15
- Төрөл :	 
- Хэрэглээний үе шат:	   
- Хэрэглээ :	

ТАЙЛБАР	
Нэр:	UNEP-ийн шууд тайлагнах мэдээллийн систем (IRIS)
Үндсэн агуулга ба зорилго:	UNEP Live нь дэлхийн, бүс нутгийн болон үндэсний байгаль орчны мэдээлэл, удирдамжид нээлттэй нэвтрэх боломжийг хангахад чиглэсэн динамик, интерактив дүн шинжилгээ, тайлагналын систем юм. Энэхүү хэрэгслийн тусламжтайгаар үндэсний, бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд мэдээлэх үүрэгтэй засгийн газрын яам, агентлагууд байгаль орчны талаарх өндөр чанартай мэдээллийг цаг тухайд нь нийтэлж, улмаар цуглуулж, дүн шинжилгээ хийх боломжтой болдог. UNEP Live нь олон тооны аналитик, зураглал, хайлт, дүрслэх хэрэгслийг багтаасан бөгөөд SDGs /MEAs sinergies порталыг багтаасан болно.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2019
Баталсан субъект:	Үндэсний статистикийн хороонд туршиж байна
Төрөл:	Тайлан
Эх сурвалж:	https://environmentlive.unep.org/
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	Байгаль орчинтой холбоотой ТХЗ
Ангиллын код:	ME16
- Төрөл :	
- Хэрэглээний үе шат:	 
- Хэрэглээ :	 




Дугаар 24




ТАЙЛБАР	
Нэр:	Сав газрын талуудын оролцооны зөвлөл байгуулах, ажиллах журам
Үндсэн агуулга ба зорилго:	Усны сав газрын талуудын оролцооны зөвлөл байгуулах, тухайн сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөлт, хэрэгжилтэд талуудын оролцоог хангах, сав газрын захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах харилцааг зохицуулахад оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд, Усны сав газар
Батлагдсан огноо:	2018 оны 3 дугаар сарын 13-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-57 дугаар тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://eic.mn/legalinfo/upload/2018/talegalan-nex/20180313_8394_731.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.1
Ангиллын код:	ML1
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 25




ТАЙЛБАР	
Нэр:	Улаанбаатар хотын гэр хорооллын өрхүүдийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах нь (зөвлөмж)
Үндсэн агуулга ба зорилго:	Хурдацтай тэлж буй Улаанбаатар хотын гэр хороолол, захын суурьшил ариун цэврийн байгууламжийг хэрхэн сайжруулах талаар шийдвэр гаргахад Улаанбаатар хотын засаг захиргааны шийдвэр гаргагчид болон бусад оролцогч талуудад тустай зөвлөмж юм.
Хамрах хүрээ:	Улаанбаатар хотын хэмжээнд
Батлагдсан огноо:	2017 оны 6 сар
Баталсан субъект:	Дэлхийн банк
Төрөл:	Зөвлөмж
Эх сурвалж:	http://documents.worldbank.org/curated/en/181361542870949296/pdf/122879-WP-Mong.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.2, 6.3, 15.5
Ангиллын код:	ML2
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	

Дугаар 26




ТАЙЛБАР	
Нэр:	Нүхэн жорлон, угаадасны нүх: Техникийн шаардлага MNS 5924 : 2015
Үндсэн агуулга ба зорилго:	Стандартын зорилго нь хүн амын амьдрах аюулгүй орчин бүрдүүлэх, байгаль орчныг бохирдлоос хамгаалах, халдварт өвчин үүсэхээс урьдчилан сэргийлэхэд оршино. Техникийн шаардлага MNS 5924:2015.
Хамрах хүрээ:	Төвлөрсөн болон бие даасан ариутгах татуургын системд холбох боломжгүй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд
Батлагдсан огноо:	2015 оны 12 дугаар сарын 24-ний өдөр
Баталсан субъект:	Стандартчиллын үндэсний зөвлөлийн 59 дүгээр тогтоол
Төрөл:	Стандарт
Эх сурвалж:	http://estandard.gov.mn/standart/reader/1873
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.2, 6.3, 15.5
Ангиллын код:	ML3
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	

ТАЙЛБАР	
Нэр:	Ашигт малтмал олборлох, боловсруулах явцад үүсэх хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, экологийн хохирол тооцох аргачлал
Үндсэн агуулга ба зорилго:	Ашигт малтмалыг олборлох, боловсруулахад үүсэх хохирлын хэмжээг эдийн засгийн үнэлгээгээр тооцож тогтоох, экологийн хохирлын төлбөр, нөхөн төлбөрийг тооцох зэрэг хариуцлагын механизмыг бүрдүүлэх ач холбогдолтой юм. Экологийн хохирлын үнэлгээ нь байгаль орчинд буюу байгалийн нөөцөд учирсан хохирлын хэмжээг тооцож, түүнийг нөхөн сэргээхэд шаардагдах хөрөнгийн тооцоолол болох бөгөөд ус, хөрс, ургамал, ой, зэрлэг ан амьтад, тэдгээрийн төрөл зүйлийн амьдрах орчинд учирсан хохирол болон түүнээс үүдэж нийгэмд учирч болзошгүй хохирлыг цогцоор авч үзэхэд оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2008 оны 6 дугаар сарын 3-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчны сайдын 207 тоот тушаал
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/5047?law-id=7500
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.6, 15.1, 15.4, 15.8
Ангиллын код:	ML4
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	






ТАЙЛБАР	
Нэр:	Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга (BIOFIN)
Үндсэн агуулга ба зорилго:	BIOFIN нь улс орнуудын биологийн олон янз байдлын одоогийн зардлыг хэмжих, биологийн олон янз байдлын санхүүжилтийн хэрэгцээг дунд хугацаанд үнэлэх, биологийн олон янз байдлын санхүүжилтийн зөрүүг арилгах санхүүгийн хамгийн оновчтой шийдлийг тодорхойлох боломжийг олгодог аргачлал юм. Уг аргачлал нь биологийн олон янз байдлын санхүүжилтийн үндэсний түншлэлийг бий болгохоос эхэлдэг бөгөөд үүний дотор төр, хувийн хэвшлийн хоорондын түншлэл бий болох, биологийн олон янз байдлын санхүүжилтийн зөрүүг арилгах шийдлийг тодорхойлж, эрэмбэлэх биологийн олон янз байдлын санхүүжилтийн төлөвлөгөө боловсруулах зэрэг багтана.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2015 оны 9 дүгээр сар
Баталсан субъект:	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд хэрэгжсэн
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	http://biodiversityfinance.net/mongolia
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	TX3 6, TX3 15
Ангиллын код:	ML5
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	






ТАЙЛБАР	
Нэр:	ValuES тооцооллын мэдээллийн сан
Үндсэн агуулга ба зорилго:	ValuES аргын мэдээллийн сан нь Экосистемийн үйлчилгээг бодлого, төлөвлөгөөнд нэгтгэх зорилгоор байгалийн баялаг (экосистемийн үйлчилгээ) үнэлгээ хийх аргуудын мэдээллийн сан юм. Үүнийг бодлогын чиглэл, зорилго, арга хэлбэр, эсвэл экосистемийн үйлчилгээгээр хайж болно. Монгол Улсад Туул голын эх, түүний сав газарт энэ аргачлалыг ашиглаж хийсэн үнэлгээ бий.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2009 он
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хэрэгжсэн
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	http://www.aboutvalues.net/data/case_studies/values_case_study_conserving_watershed_mongolia.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.6, 15.1, 15.4, 15.8
Ангиллын код:	ML6
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 30




ТАЙЛБАР	
Нэр:	Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал
Үндсэн агуулга ба зорилго:	Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 15.1.-т заасны дагуу газрын эдийн засгийн үнэлгээг газрын суурь үнэ, төлбөрийн хэмжээг тогтоох, газрын өгөөжийг тодорхойлоход энэхүү аргачлалыг ашиглана.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2018 оны 6 дугаар сарын 20-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 181 дүгээр тогтоол
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/8628?law-id=13597
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.1
Ангиллын код:	MD1
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 31

ТАЙЛБАР	
Нэр:	Газар зохион байгуулалт хийх журам
Үндсэн агуулга ба зорилго:	Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу газар зохион байгуулалт хийхэд энэ журмыг дагаж мөрдөнө.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2003 оны 2 дугаар сарын 7-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/847?law-id=4956
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.1
Ангиллын код:	MD2
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	 
- Хэрэглээ:	 





ТАЙЛБАР	
Нэр:	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам
Үндсэн агуулга ба зорилго:	Монгол Улсын иргэнд өмчлүүлэх болон иргэний өмчийн газар, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон тэдний эзэмшиж, ашиглаж байгаа газар, гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль тогтоомжийн дагуу ашиглуулах болон ашиглуулж байгаа газарт, түүнчлэн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоогүй төрийн өмчийн бусад газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийхэд энэ журмыг дагаж мөрдөнө.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2003 оны 2 дугаар сарын 7-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/845?law-id=4956
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.1
Ангиллын код:	MD3
- Төрөл:	 
- Хэрэглээний үе шат:	 
- Хэрэглээ:	

ТАЙЛБАР	
Нэр:	Ойгоос мод бэлтгэх журам
Үндсэн агуулга ба зорилго:	Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалсан байгаль орчинд халгүй технологиор ойн нөөцийг зохистой, тогтвортой ашиглахад чиглэсэн зөв төлөвлөлт, хуваарилалт, хяналт бүхий мод бэлтгэлийн тогтолцоо бий болгохтой холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг ашиглана.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2016 оны 12 дугаар сарын 13-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/133 дугаар тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/2017.2.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.2, 15.4, 15.b
Ангиллын код:	MD4
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




ТАЙЛБАР	
Нэр:	Ойг хамгаалах, тарьц, суулгац ургуулах ажлыг урамшуулах журам
Үндсэн агуулга ба зорилго:	Түймэр, ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж тарьц, суулгац ургуулсан, иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох харилцааг зохицуулна.
Хамрах хүрээ:	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага
Батлагдсан огноо:	2015 оны 3 дугаар сарын 31-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан А-140/63 дугаар тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/2015.3.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.2, 15.4, 15.b
Ангиллын код:	MD5
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	





ТАЙЛБАР	
Нэр:	Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам
Үндсэн агуулга ба зорилго:	Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнээс сэргийлэх, ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулж, урамшуулах харилцааг зохицуулахад оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2010 оны 3 дугаар сарын 10-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 59 дүгээр тогтоол
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/2610?lawid=2686
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.2, 15.4, 15.b
Ангиллын код:	MD6
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	





Дугаар 36

ТАЙЛБАР	
Нэр:	Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам
Үндсэн агуулга ба зорилго:	Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2013 оны 3 дугаар сарын 16-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 93 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/5810?law-id=9108
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.4, 15.7, 15.8
Ангиллын код:	MD7
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	 





Дугаар 37

ТАЙЛБАР	
Нэр:	Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам
Үндсэн агуулга ба зорилго:	Аймаг, нийслэл, сум, дүүргийн болон агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах, агнуур зохион байгуулалтыг гүйцэтгэх мэргэжлийн байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2013 оны 3 дугаар сарын 16-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 93 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/5809?lawid=9108
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.4, 15.7, 15.8
Ангиллын код:	MD8
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	





ТАЙЛБАР	
Нэр:	Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт олгох, хяналт тавих журам
Үндсэн агуулга ба зорилго:	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ан агнах, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, тээвэрлэх, үйл ажиллагаанд төв болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас хяналт тавих, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулна.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/BOAJS.2017.04.03.A.75.An-amitan-tedgeeriin-garaltai-tu-uhii-edii.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.4, 15.7, 15.8
Ангиллын код:	MD9
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	 

ТАЙЛБАР	
Нэр:	Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам
Үндсэн агуулга ба зорилго:	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилийн боомт, гүний гаалиар нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэх үед хорио цээрийн хяналт шалгалт хийж мал, амьтны олон улсын «А» жагсаалтын гоц халдварт өвчин, мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчин, ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, хог ургамал, мэрэгч амьтан хилээр нэвтрэх, дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2003 оны 7 дугаар сарын 15-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/978?law-id=2690
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	12.2, 15.7, 15.8
Ангиллын код:	MD10
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	 




Дугаар 40




ТАЙЛБАР	
Нэр:	Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам
Үндсэн агуулга ба зорилго:	Монгол Улсын хилээр нэвтрүүлэх мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ (сертификат) олгох, эдгээртэй холбогдон мэргэжлийн хяналтын байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2003 оны 7 дугаар сарын 15-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/979?lawid=2690
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.4, 15.7, 15.8
Ангиллын код:	MD11
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	 

Дугаар 41




ТАЙЛБАР	
Нэр:	Ургамлын нөхөн төлбөрийг төлүүлэх журам, аргачлал
Үндсэн агуулга ба зорилго:	Байгалийн ургамлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д заасан ургамлын санд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхэд энэхүү журам, аргачлалыг дагаж мөрдөнө.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2011 он
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-354 дүгээр тушаал
Төрөл:	Журам, аргачлал
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/5535?lawid=8173
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	15.7, 15.a
Ангиллын код:	MD12
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	 

Дугаар 42




ТАЙЛБАР	
Нэр:	Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам
Үндсэн агуулга ба зорилго:	Тохиолдож болзошгүй гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний үндэс болох гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний ажлыг гүйцэтгэхэд энэхүү журмыг мөрдөнө.
Хамрах хүрээ:	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо болон аж ахуйн нэгж, байгууллага
Батлагдсан огноо:	2006 оны 7 дугаар сарын 19-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 176 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://mecss.gov.mn/law/279/
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	13.1
Ангиллын код:	MO1
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	

ТАЙЛБАР	
Нэр:	“Монгол инновац” - Бодлогын зөвлөмж
Үндсэн агуулга ба зорилго:	Гарааны бизнесийн эко орчныг бүрдүүлэх, инновацын платформыг байгуулж мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх асуудлаар бодлого боловсруулагчид, гарааны бизнес эрхлэгчид, энтрепренёрууд болон эрдэмтэн судлаачдын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, салбарын хөгжлийн талаар нэгдсэн ойлголтод хүрч, бодлогын зөвлөмжийг гаргасан.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2016 оны 10 сар
Баталсан субъект:	МТҮП-ын Инкубатор, бизнес хөгжүүлэлтийн төв
Төрөл:	Зөвлөмж
Эх сурвалж:	http://itpark.mn/wp-content/uploads/2016/10/mon-gol-innovatoion_meeting1.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	8.1, 8.2, 9.b, 9.5
Ангиллын код:	M02
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 44

ТАЙЛБАР	
Нэр:	Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
Үндсэн агуулга ба зорилго:	Усны нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдол, усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэхэд ашиглана.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд, усны 29 сав газраар
Батлагдсан огноо:	2011 оны 10 дугаар сарын 26-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/law/details/4588
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.4, 6.6, 15.1
Ангиллын код:	MW1
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 45

ТАЙЛБАР	
Нэр:	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм
Үндсэн агуулга ба зорилго:	Гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	1997 оны 10 дугаар сарын 21-ний өдөр
Баталсан субъект:	Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 143/А/352 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт
Төрөл:	Дүрэм
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/4384?law-id=7618
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.4, 6.6
Ангиллын код:	MW2
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	





Дугаар 46

ТАЙЛБАР	
Нэр:	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
Үндсэн агуулга ба зорилго:	Усны тухай хуулийн 22.4 дэх хэсгийг үндэслэн усны эх, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт тогтоох онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн зааг, эдгээр бүсэд мөрдөх дэглэмийг тогтооход оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2015 оны 6 дугаар сарын 5-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын А/230/127 дугаар хамтарсан тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/2015.4.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.3
Ангиллын код:	MW3
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	





Дугаар 47

ТАЙЛБАР	
Нэр:	Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн журам
Үндсэн агуулга ба зорилго:	Тодорхой нутаг дэвсгэрт тохиолдсон ган, цөлжилт, хуурайшилт зэрэг уур амьсгалын сөрөг үзэгдлийн үед ган, цөлжилт, хуурайшилтын төлөв байдлын зэрэглэлийг тогтоох, тухайн нөхцөлд тохирсон усны нөөцийн зөв зохистой хуваарилалтын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд, ган, цөлжилт, хуурайшилт ихтэй газрын хэмжээнд
Батлагдсан огноо:	2013 оны 3 дугаар сарын 1-ний өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-66 дугаар тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/6107?law-id=9635
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.5, 15.3
Ангиллын код:	MW4
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 48

ТАЙЛБАР	
Нэр:	Унд ахуйн зориулалттай усны объектын усны чанарын норм, шаардлага
Үндсэн агуулга ба зорилго:	Гадаргын болон газрын доорх унд ахуйн зориулалттай усны объектын усны чанарын норм, тавигдах шаардлагыг энэхүү хэм хэмжээгээр тогтоож өгсөн.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	1997 оны 10 дугаар сарын 21-ний өдөр
Баталсан субъект:	Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 143/А/352 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт
Төрөл:	Норм, шаардлага
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/4384?law-id=7618
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.2
Ангиллын код:	MW5
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	 
- Хэрэглээ:	





Дугаар 49

ТАЙЛБАР	
Нэр:	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм
Үндсэн агуулга ба зорилго:	Гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	1997 оны 10 дугаар сарын 21-ний өдөр
Баталсан субъект:	Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 143/А/352 дугаар хамтарсан тушаалын 3, Тогтвортой хөгжил-Дээд боловсрол 4 дүгээр хавсралт
Төрөл:	Дүрэм
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/4384?lawid=7618
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.2
Ангиллын код:	MW6
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	 
- Хэрэглээ:	




Дугаар 50




ТАЙЛБАР	
Нэр:	Унд ахуйн ус ашиглалтын зориулалттай усны объектод байх хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Үндсэн агуулга ба зорилго:	Унд ахуйн ус ашиглалтын зориулалттай усны объектод байх хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг энэхүү эрх зүйн актаар тодорхойлж өгсөн.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	1997 оны 10 дугаар сарын 21-ний өдөр
Баталсан субъект:	Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 143/А/352 дугаар хамтарсан тушаалын 5 дугаар хавсралт
Төрөл:	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/?lawid=7618
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.2
Ангиллын код:	MW7
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	

Дугаар 51




ТАЙЛБАР	
Нэр:	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус
Үндсэн агуулга ба зорилго:	Энэхүү стандарт нь ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтээс хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоосон. MNS 4943:2015
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2015 оны 12 дугаар сарын 24-ний өдөр
Баталсан субъект:	Стандартчиллын үндэсний зөвлөлийн 50 дугаар тогтоол
Төрөл:	Стандарт
Эх сурвалж:	http://estandard.gov.mn/standart/v/3615
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.3
Ангиллын код:	MW8
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	 
- Хэрэглээ:	




Дугаар 52




ТАЙЛБАР	
Нэр:	Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам
Үндсэн агуулга ба зорилго:	Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3. дугаар заалтад "Усны нөөцийг тооцоолох, усны тоо бүртгэл явуулах, усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоох, усны хэрэглээний норм тогтоох, усны чанарыг бохирдлын индексээр үнэлэх, усны сан бүхий газрыг нөхөн сэргээх, уст цэг, усны барилга байгууламжийг ашиглах, эзэмших, ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам, зааврыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлах" гэж заасныг үндэслэн усны ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд ус олборлох, дамжуулах, нөөцлөх, борлуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа ус хангагч, усны тоолуурын хэмжил зүйн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага болон ус ашиглагч, хэрэглэгчид
Батлагдсан огноо:	2013 оны 5 дугаар сарын 16-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-156 дугаар тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/5870?law-id=9190
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.4, 6.b
Ангиллын код:	MW9
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




ТАЙЛБАР	
Нэр:	Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам
Үндсэн агуулга ба зорилго:	Усны тухай хуулийн 31.2-т заасныг үндэслэн зөвшөөрсөн хэмжээнээс илүү ус ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (ус ашиглагч)-д шатлан өсгөх хэлбэрээр төлбөр ногдуулах, төлбөрийн хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд, ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага
Батлагдсан огноо:	2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр
Баталсан субъект:	Засгийн газрын 391 дүгээр тогтоол
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/9024?law-id=13913
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.4, 6.b
Ангиллын код:	MW10
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	




Дугаар 54




ТАЙЛБАР	
Нэр:	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага
Үндсэн агуулга ба зорилго:	Уг норм, тавигдах шаардлага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн норм, тавигдах шаардлага хангасан загвар орчин бүрдүүлэх, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулахад оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд, Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрууд
Батлагдсан огноо:	2015 оны 6 дугаар сарын 29-ний өдөр
Баталсан субъект:	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан А/253/251/173 дугаар тушаал
Төрөл:	Норм, шаардлага
Эх сурвалж:	http://www.wins4girls.org/resources/2015%20Mongolia%20Guideline%20for%20Implementation%20of%20National%20Norms.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.2
Ангиллын код:	MW11
- Төрөл:	
- Хэрэглээний үе шат:	
- Хэрэглээ:	

ТАЙЛБАР	
Нэр:	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам
Үндсэн агуулга ба зорилго:	Аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох зөвшөөрөл олгох эрх зүйн хэм хэмжээг тогтоон зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2018 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/18 дугаар тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	http://www.mne.mn/wp-content/uploads/2018/05/BOA-JS.2018.01.30.A.18.Ayultai-hog-hayagdlig-teeverleh-tsu-gluulah-...juram-zovshoorol.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	12.4
Ангиллын код:	MR1
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
Хэрэглээ:	




ТАЙЛБАР	
Нэр:	Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам
Үндсэн агуулга ба зорилго:	Хог хаягдлын менежментийн мэдээллийг бүрдүүлэх, мэдээллээр хангах хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоотой холбоотой харилцааг зохицуулна.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/428 дугаар тушаал
Төрөл:	Журам
Эх сурвалж:	http://www.mne.mn/wp-content/uploads/2018/12/medeellin-san.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	12.5
Ангиллын код:	MR2
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
Хэрэглээ:	

ТАЙЛБАР	
Нэр:	Ногоон худалдан авалтын журам
Үндсэн агуулга ба зорилго:	2014 онд УИХ-аар батлагдсан Ногоон хөгжлийн бодлогод “ногоон худалдан авалт” гэж “эрчим хүч, байгалийн нөөц баялгийн хэмнэлттэй хэрэглээ, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хэлнэ” хэмээн тодорхойлсон. Аливаа бүтээгдэхүүний үйлдвэрлэл ямагт байгаль орчинд хор нөлөө үзүүлж байдгийг анхаарч ухаалаг, ногоон худалдан авалт хийхийг эрмэлзэх, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал нь худалдан авалтын зардлаас ямагт олон дахин их байдгийг анхаарч үр ашигтай, ашиглалтын зардал багатай төхөөрөмж сонгоход оршино.
Хамрах хүрээ:	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага
Батлагдсан огноо:	2013 оны 5 дугаар сарын 22-ны өдөр
Баталсан субъект:	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын даргын 142 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://archive.iges.or.jp/files/research/climate-energy/mm/PDF/20161214/1_1_3.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	12.7
Ангиллын код:	MR3
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
Хэрэглээ:	




ТАЙЛБАР	
Нэр:	“Тогтвортой хөгжил-Дээд боловсрол” зөвлөмж
Үндсэн агуулга ба зорилго:	Монголын их, дээд сургуулиуд, коллежуудад зориулсан дээд боловсролын засаглал, эрх зүй, санхүүжилт, сургалтын хөтөлбөр, чанарын шинэчлэл, хүний нөөц-багшийн хөгжил, оюутны хөгжил, нийгмийн баталгаа, судалгаа шинжилгээ, инновацын чиглэлээрх асуудлыг хэлэлцэн, гарц шийдлийг тодорхойлсон зөвлөмж.
Хамрах хүрээ:	Монголын их, дээд сургуулиуд, коллежууд
Батлагдсан огноо:	2018 оны 3 дугаар сарын 27-ны өдөр
Баталсан субъект:	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 1а/2718 дугаар албан бичиг
Төрөл:	Зөвлөмж
Эх сурвалж:	https://www.must.edu.mn/mn/content/show/id/7613
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	12.8
Ангиллын код:	MR4
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
Хэрэглээ:	

ТАЙЛБАР	
Нэр:	Ногоон оффисын менежментийн аргачлал
Үндсэн агуулга ба зорилго:	Оффисын тоног төхөөрөмж, бичиг хэргийн материалын ашиглалт, тээвэр, эрчим хүч, ус, хог хаягдлын байгаль орчинд ээлтэй, ногоон хэв маяг, дадлыг бүрдүүлэхэд чиглэсэн менежмент, зөвлөмж бүхий аргачлал.
Хамрах хүрээ:	Аж ахуйн нэгж, байгууллага
Батлагдсан огноо:	2013 оны 5 дугаар сарын 22-ны өдөр
Баталсан субъект:	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын даргын 142 дугаар тушаалын 2 дугаар хавсралт
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://archive.iges.or.jp/files/research/climate-energy/mm/PDF/20161214/1_1_3.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	12.8
Ангиллын код:	MR5
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
Хэрэглээ:	




Дугаар 60

ТАЙЛБАР	
Нэр:	Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журам
Үндсэн агуулга ба зорилго:	Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжид ангилал тогтоох, аялал жуулчлалын ажил үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл, ангиллын төрлүүд, эрх олгохтой холбоотой харилцааг зохицуулна.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2009 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 31 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт
Төрөл:	Журам
Эх сурвалж:	https://www.legalinfo.mn/annex/details/5117?law-id=8127
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	12.b
Ангиллын код:	MR6
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
Хэрэглээ:	

Дугаар 61

ТАЙЛБАР	
Нэр:	Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага
Үндсэн агуулга ба зорилго:	Амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэд энэхүү стандартыг мөрдөн ажиллаж, үйл ажиллагаандаа хяналт тавина. MNS 6043:2009
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд
Батлагдсан огноо:	2009 оны 12 дугаар сарын 24-ний өдөр
Баталсан субъект:	Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 45 дугаар тогтоол
Төрөл:	Стандарт
Эх сурвалж:	http://estandard.gov.mn/standart/v/2750
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	12.b
Ангиллын код:	MR7
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
Хэрэглээ:	

Дугаар 62

ТАЙЛБАР	
Нэр:	Бичил уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх аргачлал
Үндсэн агуулга ба зорилго:	Бичил уурхайн олборлолтын улмаас эвдэрч доройтсон газрыг байгалийн унаган төрхөд ойртуулан, олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байдлаар нөхөн сэргээхэд оршино.
Хамрах хүрээ:	Улсын хэмжээнд, эвдрэлд өртсөн газар
Батлагдсан огноо:	2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр
Баталсан субъект:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан А/226-А/182 дугаар тушаал
Төрөл:	Аргачлал
Эх сурвалж:	https://asmhub.mn/uploads/files/bay-gal-orchny-nkhn-sergeeltiyn-argachlal.pdf
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах байдал:	6.6, 12.2, 15.1, 15.4, 15.5
Ангиллын код:	MR8
Төрөл:	
Хэрэглээний үе шат:	
Хэрэглээ:	


2.2. Дүгнэлт

Энэхүү судалгааны явцад авч үзсэн Монгол Улсад хэрэглэж, туршсан 62 арга хэрэгслийн 12 нь АХБ-ны эмхэтгэлд дурдагдсан байна. Тэдгээрийг төрлөөр нь авч үзвэл бүтцийн хүрээг бий болгох арга хэрэгсэл (**framework tool**) цөөхөн байна. Бодлогын мөчлөг талаас нь авч үзвэл цөөн тооны хэрэгжилтийн үе шатны болон боловсруулж, батлуулах шатны арга хэрэгсэл ашиглаж байна.

Үндэсний түвшинд хэвшүүлсэн арга хэрэгслээс харахад тэдгээрийн аль нь ч тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилго, зорилтуудыг цогцоор нь хамрахгүй байгаа нь илэрхий байх бөгөөд ихэвчлэн маш тодорхой зорилтуудад чиглэгдсэн байна. Түүнээс гадна агуулгын хувьд зарим арга хэрэгсэл нь ТХЗ-ын ижил төстэй зорилтуудад давхар чиглэсэн дүр зураг ажиглагдсан. Энэ нь байгаль орчны асуудлуудыг нийтэд нь хамрахад чиглэгдсэн арга хэрэгсэл бий болгох хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна (Зураг 3).

Харин судлагдсан арга хэрэгслүүдээс "Хүснэгт 2-т харуулсан ME12 кодтой "Шүүлтүүрийн шинжилгээний аргачлал (filtration analysis)"-ын хамрах хүрээг дээр сонгосон ТХЗ-ын 48 зорилтод чиглүүлж, үйлчлэх түвшинг орон нутгийн түвшнээс улсын хэмжээд болгон өргөжүүлэн ашиглах боломжтой гэж үзсэн. Мөн энэхүү арга хэрэгслийн хэрэглэхэд хялбар байдал нь давуу тал болж байна. Тиймээс цаашид арга хэрэгсэл боловсруулах ажилд энэ хэрэгслийн хүчин зүйлсийг ашиглах саналыг дэвшүүлж байна.

Зураг 3. Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудад үндэсний түвшинд хэвшүүлсэн арга хэрэгслийн харгалзах байдал, давтамжаар



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

3. ОЛОН УЛСАД ХЭВШҮҮЛСЭН АРГА ХЭРЭГСЛИЙН ТОЙМ

3.1. Олон улсад хэрэглэж буй арга хэрэгслийн нэгтгэл

Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилго (ялангуяа ТХЗ 6, 12, 15)-ыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогод тусгахад ашиглаж болохуйц арга хэрэгслийг олон улсын түвшинд судалж тайлангийн энэ хэсэгт танилцуулав. Чингэхдээ, тайлангийн 1 дэх хэсэгт дурдсан шалгууруудыг баримтласан.

Олон улсын түвшинд арга хэрэгслийг судлахад ашигласан мэдээллийн гол эх сурвалж нь АХБ-ны энэхүү төслийн (ТА-9245) 1-р үе шатанд хэвлэгдсэн эмхэтгэл бөгөөд бусад эх сурвалжуудыг дор дурдав. Үүнд:

- ЭЗХАХБ (OECD), Байгаль орчин, эдийн засгийн өсөлтийн тайлан (OECD work on environment)
- НҮБ-ын системд ТХЗ, төрийн удирдлага, (UNDESA) зэрэг хайлтууд
- Судалгааны байгууллагууд тухайлбал Стокгольм дахь Байгаль орчны хүрээлэнгээс (SEI) боловсруулсан арга хэрэгсэл (LEAP, WEAP, REAP, LEAP-IBC)
- UN Global Compact байгууллагаас гаргасан бизнес эрхлэлтийг хөгжүүлэхэд чиглэсэн 200 гаруй эх сурвалж
- Биологийн олон янз байдлын чиглэлээрх (SDG Tool) цахим хуудас

Дээр тоочсон эх сурвалжид дурдсан арга хэрэгслийн зарим нь АХБ-ны эмхэтгэлд, мөн багтсан байна.

Хүснэгт 3. АХБ-ны эмхэтгэлээс тохирох ангилал [(i) Бүтцийн хүрээг бий болгох арга хэрэгсэл (framework tool) төрлийн бөгөөд (ii) Асуудлыг болон түүний хамрах хүрээг тодорхойлох үе шат (Issue, framework identification or Policy formulation) эсвэл (iii) Асуудлыг шийдвэрлэх, бодлогыг төлөвлөх, боловсруулах, батлах үе шатанд ашиглагдах (iv) Стратегийн хэрэглээний арга хэрэгсэл]-ын дагуу сонгосон арга хэрэгсэл

#	Код	Арга/ Хэрэгслийн нэр	Төрөл				Хэрэглэх үе шат				Хэрхэн хэрэглэх										
			Бүтцийн хүрээг бий болгох (framework tool)	Чиглүүлэх хэрэгсэл (guidance tool)	Арга зүйн (процесс)-ийн хэрэгсэл (methodology tool)	Бие даасан хэрэгсэл (standalone tool)	Асуудал, хамрах хүрээг тодорхойлох (issue identification and framing)	Боловруулж, батлуулах (formulation and drafting)	Хэрэгжүүлэх (implementation)	Хяналт, үнэлгээ хийх (monitoring, evaluating and reporting)	Стратегийн хэрэгсэл (strategic tool)	Процессын хэрэгсэл (procedural tool)	Зохион байгуулалтын хэрэгсэл (organizational tool)								
1	G1	Элсэн цагийн загвар (Daily Triangle and Hourglass Model)																			
2	G2	Эдийн засгийн цагариган бүрхүүл (Doughnut Economics)																			
3	G3	Тогтвортой хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлт (Integrated Policymaking for Sustainable Development)																			
4	G4	Уялдуулах, эрчимжүүлэх бодлогын дэмжлэг үзүүлэх үндсэн чиглэл (MAPS)																			
5	G27	Бутан Улсын үндэсний нийт аз жаргал (GNH)-ын бодлого төлөвлөлтийн чанарын шинжилгээний																			
6	E2	Байгалийн нөөц баялгийн менежментийн нэгдсэн хандлага (Nexus Approach)																			
7	E3	Байгаль орчин-эдийн засгийн данс (SEEA)																			

Энэ хэсэгт Хүснэгт 3 дах арга хэрэгсэл тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг АХБ-ны эмхэтгэлд харуулсан байдлаар нь оруулсан бөгөөд тухайн арга хэрэгслийн чиглэл, хэрэглэх үе шат болон төрлийг зургаар дүрсэлсэн. Холбогдох тайлбар, мэдээллийг энэ хэсгээс харах боломжтой.

G1
Элсэн цагийн загвар (Daily Triangle and Hourglass Model)

ТАЙЛБАР

Эдийн засаг хэрхэн байгалийн нөөц, экосистемийн үйлчилгээ зэрэг байгалийн баялаг дээр суурилан бий болдгийг элсэн цагийн загварын эхэн үеийн гурвалжин загвараар дүрслэн харуулдаг. Эдийн засаг, хүний нийгмийн хөгжлийг байгалийн баялаггүйгээр бүтээх боломжгүй нь эдгээр загваруудаас тодорхой харагддаг бөгөөд хожуу үеийн загвар нь байгалийн баялаг болон түүнийг ашиглан бий болох нийгэм, эдийн засгийн хөгжлийг адил ач холбогдолтойгоор авч үзэн хоёр гурвалжингийн огтлолцол буюу элсэн цагаар дүрсэлдэг.

Стратеги

	Хэрэглээ
	Нөхцөл байдлын дүн шинжилгээ
	Боловсруулсан
	Байгаль орчны эдийн засагч Herman Daly 1973 онд үзэл санааг нь боловсруулсан
	Хэрэглэх нөхцөл
	Нээлттэй эх сурвалж

G2
Эдийн засгийн цагариг бүрхүүл (Doughnut Economics)

ТАЙЛБАР

Энэхүү хандлагад гаригийн байгалийн нөөц бололцооны хязгаарын хүрээнд хөгжил дэвшил, нийгмийн асуудлыг нийтэд нь хамруулан үнэлэх боломжийг олгодог. Цагаригийн дотор талд нийгмийн асуудлууд байх бөгөөд цагаригийн гадна хэсэг нь байгалийн нөөц боломжийн хязгаар утга байна. Харин тэдний дунд хэсэг нь хүн төрөлхтний хувьд аж төрөх боломжит орон зай гэж үздэг. Судалгаанаас харахад улс орнууд гаригийн байгалийн нөөц бололцооны хязгаарыг давсан мөртлөө нийгмийн хэм хэмжээг дутуу орхисон байна.

Стратеги

	Хэрэглээ
	Нөхцөл байдлын дүн шинжилгээ
	Боловсруулсан
	Oxfam
	Хэрэглэх нөхцөл
	Нээлттэй эх сурвалж

ТУРШЛАГА
Их Британи

G3

**Тогтвортой хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлт
(Integrated Policymaking for Sustainable Development)**



ТАЙЛБАР

Тогтвортой хөгжлийн бодлогын нэгдсэн бодлого: Гарын авлага (2009) нь тогтвортой хөгжлийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлуудыг сурталчлах зорилготой нэгдсэн бодлого боловсруулах арга зүй, удирдамжаар хангадаг. Бодлого боловсруулах үйл явцад үүсэх саад бэрхшээлүүдийг улс төрийн дэмжлэг, засаг захиргааны үйл ажиллагаа болон аналитик чадварын хүрээнд авч үздэг.

Стратеги



Хэрэглээ

- Зохион байгуулалт, түншлэл
- Талуудын оролцоо
- Стратегийн харилцаа холбоо, мэдлэгийг дээшлүүлэх
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Стратегийн харилцан хамаарлын дүн шинжилгээ
- Стратеги төлөвлөлт
- Саад бэрхшээлийн шинжилгээ
- Мэдээллийн удирдлага, тайлагнах, баталгаажуулах
- Сургалт, чадавхийг хөгжүүлэх

Процесс



Боловсруулсан

Хэрэглэх нөхцөл

United Nations Environment Programme (UNEP)

Нээлттэй эх сурвалж

Зохион байгуулалт



G4

**Уялдуулах, эрчимжүүлэх бодлогын
дэмжлэг үзүүлэх үндсэн чиглэл (MAPS)**



ТАЙЛБАР

MAPS нь ТХЗ-ыг улс, орон нутгийн одоогийн институцийн бүтцэд нэгтгэхэд чиглэсэн удирдамжийг Засгийн газарт өгөхөд ашигладаг. Үүнд гурван гол чиглэлийг авч үзнэ.

- Уялдуулан тусгах. "Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр - 2030" болон ТХЗ-ын талаархи мэдлэгийг дээшлүүлж, үндэсний бодлого төлөвлөлт, төсвийн үйл явцад тусгах боломжийг олгох.
- Эрчимжүүлэх. Тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэл, хүчин зүйлс, саад бэрхшээлийн талаарх шинжилгээний ажлыг бодлого боловсруулагчдад танилцуулах.
- Бодлогын дэмжлэг. Харилцан уялдаатай, нэгдсэн арга зүйг боловсруулж НҮБ-д өөрийн техникийн мэдлэг, зөвлөгөөг Засгийн газарт үр дүнтэй хүргэн, хамран ажиллах боломжийг бий болгох.

MAPS нь улсын хэмжээнд ТХЗ-ын амжилттай хэрэгжүүлэх гурван чухал нөхцөл болох түншлэлийг хөгжүүлэх дэмжлэг үзүүлэх, хариуцлагыг бий болгох, мэдээллийн чадавхыг хянах асуудлуудыг чухалчлан авч үздэг

Стратеги



Хэрэглээ

- Зохион байгуулалт, түншлэл
- Стратегийн харилцаа холбоо, мэдлэгийг дээшлүүлэх
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Стратеги төлөвлөлт
- Саад бэрхшээлийн шинжилгээ
- Төсөв төлөвлөлт
- Мэдээллийн удирдлага, тайлагнах, баталгаажуулалт
- Сургалт, чадавхийг хөгжүүлэх

Процесс



Боловсруулсан

Хэрэглэх нөхцөл

United Nations Development Group (UNDG)

Нээлттэй эх сурвалж

Зохион байгуулалт



ТУРШЛАГА

Камбож, Индонез, Пакистан болон Филиппин

ТАЙЛБАР

Энэхүү хэрэгслийг Бутан Улсын үндэсний нийт аз жаргалын концепцийн дагуу тогтвортой хөгжлийн гурван чиглэлээр хөгжлийн бодлогыг оношлоход ашигладаг. Энэхүү үзэл баримтлал нь улс орны иргэдийн аз жаргалтай, сайн сайхан амьдрахад чиглэсэн нөхцөл байдлыг бүрдүүлэх үндэсний ухамсарт суурилдаг. Хэрвээ бодлогын баримт бичгийн төсөл хангалттай өндөр үнэлгээ аваагүй бол төслийг дахин боловсруулах шаардлагатай болно. Оноо нь багийн гишүүд зөвшилцөлд хүрсэний дараа хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд тэд бодлого, хөтөлбөрийн үр нөлөөллийг үнэлдэг байна.

Бодлогын оношилгооны энэхүү хэрэгсэл нь хөгжлийн бодлого боловсруулах үйл явцад тогтвортой хөгжлийн гурван чиглэлийг заавал харгалзан үзэх шаардлага бий болгодог. Энэ нь бодлого боловсруулахад цогц арга барил болдог. Энэ арга хэрэгслийг өнөөгийн байдлаар зөвхөн Бутан Улсад ашиглаж байгаа боловч бусад орны нөхцөл байдалд тохируулан ашиглах боломжтой.

Стратеги



Хэрэглээ

- Зохион байгуулалт, түншлэл
- Стратегийн харилцан хамаарлын дүн шинжилгээ
- Талуудын оролцоо
- Стратеги төлөвлөлт
- Зөвшилцөл бий болгох
- Нөлөөлөл ба эрсдлийн үнэлгээ

Процесс



Боловсруулсан

Хэрэглэх нөхцөл

GNH Commission, Royal Government of Bhutan

Нээлттэй эх сурвалж

ТУРШЛАГА

Бутан Улс



ТАЙЛБАР

Энэхүү арга хэрэгсэл нь байгалийн нөөц баялгийн хоорондын уялдаа хамаарлыг цогцоор нь харуулдаг. Системийн харилцан үйлчлэл, нэг систем дэх өөрчлөлт бусад системд үзүүлэх нөлөөллийг үнэлэхийн тулд нөөцийн системийн загварчлалыг ашигладаг.

“Ус, Эрчим хүч, Хүнсний аюулгүй байдал (УЭХ)-ын нэгдэл”-ийг Бонн (2011) эрдэм шинжилгээний хурлаар танилцуулсан бөгөөд хоорондын уялдаа холбоог үнэлэх арга барилын онолын үндэслэл, тэдгээрийн суурь судалгаануудыг танилцуулсан. Үүний дараа олон төрлийн арга хэрэгслүүд нэмж бий болсон.

Хил дамнансан эко систем, түүнийг ашиглах туршлага: Синтез (2018) судалгааны нийтлэлд НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (НҮБЭЗК)-ээс боловсруулсан Ус, Хоол хүнс-Эрчим хүч-Эко систем (УХЭЭ)-ийн нэгдлийг голын сав газрын системийг үнэлэхэд ашиглаж харуулсан.

Шведийн хааны технологийн институт (КТН) нь НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн газар (UNDESA)-тай хамтран Уур амьсгал, газар, эрчим хүч, усны ашиглалт (CLEWD)-ын нэгдэл загварыг Тогтвортой хөгжлийн тайлан (2015)-д танилцуулсан нь цаг уурын өөрчлөлт болон газар, эрчим хүч, усны нөөцийн хоорондын уялдаа холбоог үнэлэх техникийн боломжийг бүрдүүлсэн. Үүнтэй холбоотойгоор дэлхийн цаг уур, газар, эрчим хүч, ус ашиглалт (УГЭУ)-ын нэгдэл загвар нь цаг уурын өөрчлөлтийн янз бүрийн хувилбаруудыг харьцуулах замаар дэлхийн түвшинд уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүч, газар, усны хэрэглээ хоорондын уялдаа холбоонд дүн шинжилгээг хийх боломжийг өгч байна. Хувилбарууд нь дараах байдлаар танилцуулагдсан: (i) Суурь хувилбар, (ii) 4 °C хувилбар, (iii) 2 °C хувилбар, (iv) Нүүрстөрөгчийн татварын хувилбар.

Нэгдсэн үндэсний их сургуулийн Материаллаг шингэн, нөөцийн нэгдсэн менежментийн институт (UNU-FLORES) -ээс боловсруулсан ус-хөрс-хог хаягдлыг тогтвортой менежментийн нэгдэл аргачлалыг мөн танилцуулсан байдаг. Ядуурал-Байгаль орчин-Уур амьсгалын Нийгэмлэгээс ядуурал-байгаль орчин-цаг уурын өөрчлөлтийн нэгдэлийн загварыг хөгжүүлэн ашиглаж байна.

Стратеги



Хэрэглээ

- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Динамик туршилт ба загварчлал
- Стратегийн харилцан хамаарлын дүн шинжилгээ
- Асуудлын дүн шинжилгээ

Процесс



Боловсруулсан

Хэрэглэх нөхцөл

General/Various

Нээлттэй эх сурвалж, гэхдээ CLEWS-ийг ашиглахад компьютер болон интернэт хэрэгтэй.

ТУРШЛАГА

Ази-Номхон далайн хэд хэдэн улс оронд ашигласан.



ТАЙЛБАР

SEEA бол улс орны эдийн засаг, байгаль орчны хоорондын харилцан холбоог илэрхийлж, байгалийн хөрөнгийн нөөц, түүний өөрчлөлтийг тодорхойлох олон зорилтыг агуулсан олон улсын статистикийн стандарт арга зүйн баримт бичиг юм. SEEA нь эдийн засаг, байгаль орчны харилцан үйлчлэлийн талаарх ойлголтыг сайжруулах ач холбогдолтой бөгөөд байгаль орчинд гарсан өөрчлөлт болон хуримтлагдсан нөлөөллийг харуулна. Энэ нь байгаль орчны үзүүлэлтүүдийг нэгтгэх, тэдгээр үзүүлэлтүүд болон эдийн засгийн хоорондын уялдаа холбоог үндэсний статистикийн системд тусгахад хэрэгтэй.

SEEA 2012 Central Framework (2014) тайланд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт ойлголт, тодорхойлолт, ангилал, бүртгэх журам, хүснэгтүүдийн олон улсын стандартад нийцсэн, харьцуулж болох статистик мэдээллийг эмхтгэхэд чиглэсэн олон зүйлийг багтаасан байдаг. SEEA 2012-ийн програмууд ба өргөтгөлүүдийн талаархи нэмэлт удирдамж (2017) нь SEEA-д суурилсан байгаль-эдийн засгийн дансуудын нийтлэгч болон хэрэглэгчдийн хоорондох гүүр болж өгдөг бөгөөд эдгээр дансуудыг бодлого боловсруулалтын үйл явцад хэрхэн ашиглаж болохыг харуулдаг.

Эрчим хүчний SEEA (SEEA-Energy) нь нэг талаас байгаль орчин, эдийн засаг хоорондын энергийн урсгалыг харуулах бөгөөд эрдэс, эрчим хүчний нөөцийн хэмжээний тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг нөөцийн хүрэлцээний биет хэмжээ болон мөнгөн дүнгээр эрчим хүчний салбарын хувьд харуулах бөгөөд үүгээр байгалийн баялгийн хувь нэмэр болон элэгдлийг бүртгэх юм.

Усны SEEA (SEEA-Water) болон НҮБ-ын Статистикийн хорооноос баталсан усны статистикийн олон улсын зөвлөмж нь усны бодлогын зорилт хүрээнд гарсан ахиц дэвшилд хяналт тавих концепцийг тусдаа улс орнууд болон олон улсын хэмжээнд бүрдүүлж өгдөг.

SEEA-ийн Экосистемийн Бүртгэл (SEEA-EEA) нь экосистемийн үйлчилгээний урсгалыг хэмжих, үүнийг эдийн засаг болон хүний бусад үйл ажиллагаатай холбох ерөнхий бүтэц болдог. SEEA-EEA нь техникийн хувьд төвөгтэй учраас одоогоор SEEA-ийн арай дэвшилтэт дэд хэсэг хэлбэрээр хэрэгжиж байна.

SEEA цахим сургалтын эх сурвалжийг НҮБ-ын Статистикийн хэлтсийн цахим хаягаас авах боломжтой.

Процесс



Хэрэглээ

- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Стратегийн харилцан хамаарлын дүн шинжилгээ
- Стратеги төлөвлөлт
- Төсөв төлөвлөлт
- Хөрөнгө оруулалт, санхүүжилт
- Шалгуур үзүүлэлт боловсруулах, хэмжих
- Мэдээлэл удирдах

Боловсруулсан

UN, European Commission, Food and Agriculture Organization of the United Nations (FAO), Organisation for Economic Co-operation and Development (OECD), International Monetary Fund, and World Bank Group

Хэрэглэх нөхцөл

Нээлттэй эх сурвалж, гэхдээ SEEA-ийн талаар мэргэжлийн тодорхой мэдлэг шаардлагатай.

ТУРШЛАГА

Lessons Learned from Environmental Accounting: Findings from Nine Case Studies (2000) тайланд Филиппин зэрэг Ази

Номхон Далайн орнуудын жишээг дурьдсан.

R1**ISO 14000 цуврал
(Байгаль орчны менежментийн систем)**

ТАЙЛБАР

Энэхүү цуврал нь байгаль орчны нөлөөллийг удирдан шийдвэрлэхээр зэхэж буй байгууллагуудад зориулсан стандартын багц юм. ISO 14001:2015 нь байгаль орчны менежментийн системд төвлөрдөг бол бусад стандартууд байгаль орчны аудит, харилцаа холбоо, эко шошго, мөчлөгийн шинжилгээ зэрэг тодорхой арга барилд чиглэдэг. Эдгээр стандартыг бие биенээ дэмжих зорилгоор боловсруулсан боловч тэдгээрийг бие даан ашиглаж болно.

Стратеги



Процесс



Зохион байгуулалт



Хэрэглээ

- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Стратеги төлөвлөлт
- Нөлөөлөл ба эрсдэлийн үнэлгээ

Боловсруулсан

Хэрэглэх нөхцөл

ISO

Стандартуудыг онлайнгаар урьдчилан үзэх эсвэл ISO нарийн бичгээс худалдаж авах боломжтой. ISO 14001:2015-ийн ISO гэрчилгээ нь хөндлөнгийн аудит хийлгэж баталгаажуулахыг шаарддаг.

ТУРШЛАГА

ISO 14001-ийн гэрчилгээ 171 оронд 300,000 гаруй удаа олгогдсон байна.

R2**ISO 26000 (Нийгмийн хариуцлага)**

ТАЙЛБАР

Энэхүү стандарт нь нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэхийг зорьж буй байгууллагууд хэрэглэдэг. ISO 26000:2010 нь байгууллагуудад нийгмийн хариуцлагын тухай ойлголтыг ойлгоход тусалж, үзэл баримтлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зааварчилгаа өгдөг. Энэ нь бизнесийн хэлбэр, хэмжээ, байршлаас үл хамааран бүх байгууллагад зориулагдсан. ISO 26000 ба ТХЗ (2016) удирдамжид энэхүү стандарт нь ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулж болохыг тайлбарласан байдаг.

Стратеги



Процесс



Зохион байгуулалт



Хэрэглээ

- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Стратеги төлөвлөлт
- Нөлөөлөл ба эрсдэлийн үнэлгээ

Боловсруулсан

Хэрэглэх нөхцөл

ISO

Стандартуудыг онлайнгаар урьдчилан үзэх эсвэл ISO нарийн бичгээс худалдаж авах боломжтой.

ТУРШЛАГА

Benefits in Applying ISO 26000 - Selected Case Studies as a Result of the SR MENA Project (2016)



ТАЙЛБАР

ТХЗ-ын Луужин нь компаниудын бизнесийн стратегийг ТХЗ-той уялдуулах, мөн ТХЗ-д оруулсан хувь нэмрийг хэмжих, удирдахад чиглүүлдэг. Энэ нь томоохон ААН-үүдэд зориулан боловсруулагдсан ч жижиг, дунд бизнес эрхлэгчид хэрэглэх боломжтой юм. ТХЗ-ын Луужингийн таван бүрэлдэхүүн хэсэг нь дараах асуудлыг шийдвэрлэдэг.

- ТХЗ-ыг ойлгох;
- Тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;
- Зорилго тавих;
- Бизнесийн стратегийг уялдуулан нэгтгэх;
- Үр дүнг тайлагнах, мэдээлэх.

ТХЗ-ын Луужин нь Global Reporting Initiative (GRI) зэрэг эх сурвалжаас авсан ТХЗ-д чиглэсэн бизнесийн хэрэгслүүдийн дэлгэрэнгүй эмхэтгэл, 17 ТХЗ болон тэдгээрийн 169 зорилгод тусгайлан чиглэсэн бизнесийн арга хэрэгслийн нэгтгэлийг хамруулдаг.



Процесс



Зохион байгуулалт



Хэрэглээ

- Талуудын оролцоо
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Стратеги төлөвлөлт
- Шалгуур үзүүлэлт боловсруулах, хэмжих

Боловсруулсан

GRI, United Nations (UN) Global Compact, and World Business Council for Sustainable Development (WBCSD)

Хэрэглэх нөхцөл

Нээлттэй эх сурвалж



ТАЙЛБАР

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө (БОЯБУСҮАТ) нь Биологийн олон янз байдлын конвенц (БОЯБК)-ийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм. БОЯБУСҮАТ-ууд нь тухайн орны биологийн олон янз байдлын нөхцөл байдал, аюул заналыг тодорхойлж, биологийн олон янз байдлыг хадгалах, тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх стратеги, нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулахад ашиглагддаг. Дараах удирдамж, холбогдох материалыг энд оруулав.

- БОЯБК-ын Нарийн бичиг болон бусад эх сурвалжуудаас боловсруулсан БОЯБУСҮАТ-г боловсруулах, хэрэгжүүлэх удирдамж;
- БОЯБУСҮАТ-ний бэлтгэл ажил, харилцаа холбоо, талуудын оролцоо, биологийн олон янз байдлыг салбар хоорондын стратегитай үялдуулах, БОЯБУСҮАТ-ын хэрэгжилтийн санхүүжилтийг хамарсан сургалтын материал;
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс БОЯБУСҮАТ ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулж болохыг тайлбарласан удирдамж; ба
- Биологийн олон янз байдлын үндэсний зорилтыг улс орнуудын Айчи зорилтуудын мэдээллийн сангаас хайж болно.

Стратеги



Процесс



Зохион байгуулалт



Хэрэглээ

- | | |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> • Талуудын оролцоо • Стратегийн харилцаа холбоо • Нөхцөл байдлын дүн шинжилгээ • Стратегийн харилцан хамаарлын дүн шинжилгээ • Хөрөнгө оруулалт, санхүүжилт | <ul style="list-style-type: none"> • Шалгуур үзүүлэлт боловсруулах, хэмжих • Мэдээлэл удирдах, тайлагнах, баталгаажуулах • Сургалт, чадавхийг хөгжүүлэх |
|---|--|

Боловсруулсан

Хэрэглэх нөхцөл

Secretariat of the CBD, hosted by UN Environment

Нээлттэй эх сурвалж

ТУРШЛАГА

БНХАУ, Вьетнам



ТАЙЛБАР

Тусгай хамгаалалттай газар нутгийн ногоон жагсаалт: Стандарт, хувилбар 1.1 (2017) нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн олон улсын жишиг үзүүлэлтүүдийг танилцуулдаг. Тайланд сайн засаглал, оновчтой төлөвлөлт, үр дүнтэй менежмент, хэмнэлттэй байдлын дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн дагуух 17 шалгуур 48 үзүүлэлтийг тусган харуулсан. Тусгай хамгаалалттай газар нутгийн ногоон жагсаалт: Хэрэглэгчийн гарын авлага, хувилбар 1.1 (2018) нь ногоон жагсаалтыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, ерөнхий үзүүлэлтүүдийг үндэсний нөхцөлд нийцүүлэн тооцоолох талаар удирдамжийг оруулсан байна.

Стратеги



Процесс



Хэрэглээ

- Талуудын оролцоо
- Стратегийн харилцаа холбоо
- Алсын хараа
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Стратеги төлөвлөлт
- Үзүүлэлтийн хөгжил ба хэмжилт
- Мэдээлэл удирдлага, тайлагнах, баталгаажуулалт

Боловсруулсан

International Union for Conservation of Nature (IUCN) and the World Commission on Protected Areas

Хэрэглэх нөхцөл

Нээлттэй эх сурвалж

ТУРШЛАГА

БНХАУ, Вьетнам



ТАЙЛБАР

Эко систем ба ховордсон төрөл зүйлийн Улаан данс нь эко систем болон ховордсон төрөл зүйлийг хамгаалах төлөвийг үнэлэх ангилал бөгөөд орон нутгийн, үндэсний, бүс нутгийн, дэлхийн түвшинд ашиглах боломжтой юм.

Экосистем (хуурай газар, далай, цэнгэг ус, газрын доорх) болон ховордсон амьтдын устаж байгаа; устаж болзошгүй, эмзэг, ховордож болзошгүй эсвэл анхааралд өртөхөөргүй гэсэн стандарт ангиллуудын шалгууртай тулгаж үзнэ.

Улаан дансны үнэлгээг биологийн олон янз байдалтай холбоотой олон талт байгаль орчны гэрээ хэлэлцээр болон ТХЗ-ын зорилтуудын хэрэгжилтийг хянахад хэрэглэх боломжтой. Ховордсон зүйлийн хувьд дэлхийн IUCN-ийн Улаан дансны индекс нь шувуу, хөхтөн амьтан, хоёр нутагтан, шүрний устах эрсдэлийг, дэлхийн биологийн олон янз байдлын төлвийн өөрчлөлт, хандлагыг харуулах үзүүлэлт юм.

Холбогдох эх сурвалжийн жагсаалтыг доор харууллаа:

- [An Introduction to the IUCN Red List of Ecosystems: The Categories and Criteria for Assessing Risks to Ecosystems \(2016\)](#);
- [The Guidelines for the application of IUCN Red List of Ecosystems Categories and Criteria, Version 1.1 \(2016\)](#);
- [Guidelines for Application of the IUCN Red List Criteria at Regional and National Levels, Version 4.0 \(2012\)](#);
- [IUCN Red List Index, Guidance for National and Regional Use \(2009\)](#).

Стратеги



Процесс



Хэрэглээ

- | | |
|--|--|
| <ul style="list-style-type: none"> • Стратегийн харилцаа холбоо • Нөхцөл байдлын дүн шинжилгээ • Стратеги төлөвлөлт • Нөлөөлөл ба эрсдлийн үнэлгээ | <ul style="list-style-type: none"> • Шалгуур үзүүлэлт боловсруулах, хэмжих • Мэдээллийг зохион байгуулах, тайлагнах, баталгаажуулах • Сургалт, чадавх бэхжүүлэх |
|--|--|

Боловсруулсан

Хэрэглэх нөхцөл

IUCN

Нээлттэй эх сурвалж

ТУРШЛАГА

Непал, Филиппин, БНХАУ, Шри Ланка, Вьетнам



ТАЙЛБАР

Хинду Куш Гималайн бүсэд хэрэгжсэн Эко системийн нэгдсэн менежмент (2017) нь уулархаг бүс нутагт тогтвортой хөгжлийн чухал тулгуур болох эко системийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хөдөө орон нутаг, ландшафтын хөтөлбөр, төслийн түвшний оролцоог дэмжихэд чиглэгдсэн болно. Энэ нь Хинду Куш Гималайн бүсийн найман орны уулын орчны менежментийг дэмжих зорилгоор боловсруулагдсан боловч бусад хуурай газрын ихэнх эко системд ч хамаатай. Энэ хүрээнд бие даасан хандлагын оронд эко системийн үйлчилгээг удирдах илүү системтэй, практик хандлагыг эрэлхийлдэг.

Эко системийн үйлчилгээний менежментийн төлөвлөлт - үйл ажиллагааны гарын авлага (2017) нь уулын эко системийг удирдах, төлөвлөлт хийхэд орон нутгийн иргэд, Засгийн газарт чиглэсэн зургаан алхам бүхий аргачлалыг танилцуулсан байдаг. Энэ тайланд зүлэг, ой, хөдөө аж ахуйн газрыг эко системийн үйлчилгээнд удирдан чиглүүлэх удирдамжийг багтаасан бөгөөд ингэснээр дан ганц уулын орчинд хамаарахгүй юм. Аргачлалын алхам бүрийг нарийвчлан тайлбарласан байдаг бөгөөд үүнд, экосистемийн янз бүрийн үйлчилгээг жагсаан дүрсэлж тохирох менежментийн төлөвлөгөөг боловсруулах аргачлалыг ашиглах заавруудыг багтсан.

Стратеги



Процесс



Зохион байгуулалт



Хэрэглээ

- Зохион байгуулалт, түншлэл
- Талуудын оролцоо
- Зөвшилцөл бий болгох
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Стратегийн харилцан хамаарлын дүн шинжилгээ
- Стратеги төлөвлөлт
- Саад бэрхшээлийн шинжилгээ
- Инноваци
- Шалгуур үзүүлэлт боловсруулах, хэмжих

Боловсруулсан

Хэрэглэх нөхцөл

International Centre for Integrated Mountain
Development

Нээлттэй эх сурвалж

ТУРШЛАГА

Ази-Номхон далайн орнууд дунд Филиппин, БНХАУ, Вьетнам



ТАЙЛБАР

ХАА-н хүнсний бүтээгдэхүүний эко систем болон Биологийн олон янз байдлын үнэлгээний тогтолцоо (2018) нь хүнсний системийн эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлж буй байдал, харилцан хамааралд анхаарал хандуулах боломжийг олгодог.

Үүнд, харилцан хамаарал бүхий дөрвөн бүлэг (i) үйлдвэрлэсэн капитал, байгалийн баялаг, хүний капитал, нийгмийн капитал зэрэг хуримтлагдсан үзүүлэлтүүд; (ii) үйлдвэрлэл, хэрэглээний үйл ажиллагаа, эко системийн үйлчилгээ, худалдан авсан орц зэрэг урсгал үзүүлэлтүүд; (iii) хуримтлагдсан хөрөнгөд гарсан тоон болон чанарын өөрчлөлтийн үр дүн амьдралын чанарт гарах өөрчлөлт, үр нөлөө гэсэн хэсгүүд байдаг. Энэ чиглэлээр хөдөө аж ахуй, загасны аж ахуй, мал аж ахуй, эрдэнэ шиш, дал модны тос, будаа, тариалан зэрэг салбарт хийгдсэн судалгаа шинжилгээний материалууд түгээмэл байдаг.

Стратеги



Хэрэглээ

- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Стратегийн харилцан хамаарлын дүн шинжилгээ
- Стратеги төлөвлөлт

Боловсруулсан	Хэрэглэх нөхцөл
---------------	-----------------

The Economics of Ecosystems and Biodiversity for Agriculture and Food (TEEBAgriFood) Initiative

Нээлттэй эх сурвалж

3.2. Дүгнэлт

“Энэхүү тайлангийн 3.1 хэсэгт судалсан арга хэрэгслүүдийн дийлэнх нь нарийн цар хүрээтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн бөгөөд салбарын хөгжлийн бодлого төлөвлөгөө боловсруулагчдын хувьд ашиглахад хялбар байх шаардлагад нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, дээр дурдсан зургаан шалгуур үзүүлэлтүүдэд нийцтэй бөгөөд өргөн цар хүрээг хамарсан, ашиглахад хялбар, бодлого-оношилгооны арга хэрэгсэл төдийлөн байхгүй байна. Дээрх арга хэрэгслүүдийг ашиглахад нарийн мэргэжлийн ур чадвартай эсвэл энэ чиглэлийн сургалтад хамрагдсан байх шаардлагатай байна.

Харин Бутан Улсын үндэсний нийт аз жаргал (GNH)-ын бодлого төлөвлөлтийн чанарын шинжилгээний арга хэрэгсэл боломжит хувилбар бөгөөд үүнийг тайлангийн дараах бүлэгт дэлгэрүүлэн авч үзлээ. Гэхдээ энэхүү арга хэрэгслийг зөвхөн жишээ байдлаар ашиглах бөгөөд Монгол Улсын хувьд үүнтэй төстэй арга хэрэгслийг өөрийн онцлог нөхцөл байдал, хэрэгцээнд нийцүүлэн боловсруулах боломжтой юм.

Тогтвортой хөгжлийн зорилго 6, 12, 15-д чиглэсэн арга хэрэгсэл

ТХЗ 6

АХБ-ны эмхэтгэлд ТХЗ 6-ын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл тухайлан тусгагдаагүй бөгөөд ТХЗ 12 болон 15-ын хувьд ч мөн адил байна. Харин тус тайланд, ТХЗ 6-ын нэг зорилтыг дангаар болон хэд хэдэн зорилтыг хамруулан хангахад чиглэсэн нийт 11 арга хэрэгслийг тодорхойлов. Үүнд ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлыг хөндсөн 2 арга хэрэгсэл багтсан ч аль аль нь сонголтын шалгуурт тухайлан нийцэхгүй байна.

ТХЗ 12

АХБ-ны эмхэтгэлд “R” ангилалд 21 арга хэрэгслийг хамруулсан байдаг. Эдгээрийн олонх нь өнөөгийн нөхцөл байдал, бодлогын үйл ажиллагааны хэтийн төлөвийг тодорхойлоход түлхүү ашиглагддаг. ТХЗ 12.1-д дурдсан (10YFP) нь хөгжиж буй болон хөгжингүй орнуудад тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийг хэвшүүлэхэд олон улсын хамтын ажиллагааг сайжруулах, ахицыг хурдасгахад чиглэсэн дэлхий нийтийн арга хэмжээ юм.

Энэ тайлангийн хүрээнд хариуцлагатай хэрэглээг дэмжихэд чиглэсэн 8 арга хэрэгслийг хамруулж авч үзсэн бөгөөд эдгээрийн 4 нь төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам бусад нь аргачлал, стандарт, зөвлөмж хэлбэртэй байна.

ТХЗ 15

АХБ-ны эмхэтгэл ТХЗ 14 болон ТХЗ 15-д хамаарах 29 арга хэрэгслийг хамруулсан бөгөөд тэдгээр нь зөвхөн усны төдийгүй хуурай газрын биологийн олон янз байдлыг авч үзсэн. ТХЗ 15-ын хүрээнд гаргасан нийт 15 арга хэрэгслийг (L37-L51) оруулсан ба зорилгоос хамааран дангаар нь болон хавсруулан сонгох байдлаар хэрэглэж болно. Харин энэхүү тайланд ML1-ML6, MD1-MD12 хүртэлх нийт 18 арга хэрэгсэл багтсан.

4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой ашигладаг арга хэрэгслийн судалгааг дүгнэхэд ихэнх арга хэрэгсэл нь байгаль орчны аливаа нэг тодорхой асуудалд чиглэгдсэн байна. Тиймээс бодлого, төлөвлөлтийн өргөн цар хүрээтэй асуудлыг шийдвэрлэхээргүй байгаагийн зэрэгцээ салбар хоорондын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдаа, холбоог сайжруулах чиглэлд ашиглахад төвөгтэй байна. Өөрөөр хэлбэл, доор дурдсан зургаан шалгуур үзүүлэлтэд нийцтэй, өргөн цар хүрээг хамарсан, ашиглахад хялбар, бодлого, төлөвлөлтийн чанарын шинжилгээ хийхэд ашиглах арга хэрэгсэл одоогоор алга байна.

Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн шатанд тусгахад хэрэглэх арга хэрэгслийг судлахад дараах 6 шалгуурыг харгалзан үзсэн. Үүнд:

1. Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилгын хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн байх,
2. Үндэсний бодлогод байгаль орчны эн тэргүүний асуудлыг тусгахад ашиглах,
3. Бодлого боловсруулах шатанд ашиглах,
4. Байгаль орчны мэргэжлийн бус хүн ашиглах боломжтой, хэрэглэхэд хялбар байх,
5. Байгаль орчны талаарх бүх шатны ойлголтыг дээшлүүлэхэд дэмжлэг болох,
6. Төрийн бус бусад оролцогч талууд хэрэглэх боломжтой байх.

Энэхүү тайлангаас дараах 2 арга хэрэгсэл нь дээрх зургаан шалгуурыг хангаж байгаа бөгөөд дараагийн 2 болон 3 дах тайланд ашиглахыг санал болгов. Үүнд:

- Бутан Улсын үндэсний нийт аз жаргал (GNH)-ын бодлого төлөвлөлтийн чанарын шинжилгээний (G27) арга хэрэгсэл
- Ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтээр бодлого, төлөвлөлтийн баримт бичигт чанарын шинжилгээ хийх аргачлал¹ (filtration analysis, ME12)

Дээрх 2 аргачлалыг давуу талыг ашиглан сул талыг шийдвэрлэх замаар гуравдугаар буюу энэ тайлангийн 1 дүгээр бүлэг дэх удирдамжид нийцсэн шинэ арга хэрэгслийн ерөнхий санааг дараах байдлаар боловсруулав. Төслийн дараагийн тайланд шинэ арга хэрэгслийг бүрэн боловсруулж танилцуулах болно.

САНАЛ 1: G27 “Бутан Улсын үндэсний нийт аз жаргал (GNH)”-ын бодлого төлөвлөлтийн чанарын шинжилгээний арга хэрэгслийг жишээ байдлаар ашиглах бөгөөд Монгол Улсын хувьд үүнтэй төстэй загварыг өөрийн нөхцөл байдал, хэрэгцээнд нийцүүлэн боловсруулах боломжтой

Хэрэглээ: Энэхүү арга хэрэгсэл нь тухайн бодлогын баримт бичиг батлагдсанаар нийгмийн аз жаргал, сайн сайханд хэрхэн нөлөөлөхийг оноогоор илэрхийлж харуулна. Нийгмийн аз жаргалд сөргөөр нөлөөлж буй тохиолдолд эерэг нөлөөтэй зорилтуудыг тодорхойлж сөрөг үзүүлэлтүүдийг нөхөх шаардлагатай юм. Бодлогыг батламжлах босго оноо нь “0” гэсэн тоон утга байна.

¹ М.Алтанбагана нар (2015)

Давуу тал:	Сул тал:
<ul style="list-style-type: none"> • Бодлого төлөвлөлтийн чанарын шинжилгээнд ашигладаг • Энгийн • Хэрэглэхэд хялбар 	<ul style="list-style-type: none"> • Бодлогын баримт бичгийг зөвхөн бүхэлд нь шинжилдэг • Орхигдуулсан ТХЗ-ын зорилтыг харуулах боломжгүй • Бодлогын баримт бичгийн зорилтууд өөр өөр нөлөөтэй бол үнэлэхэд төвөгтэй

1. Stress			
Will increase levels of stress in the population	Do not know the effects on levels of stress in the population	Will not have any appreciable effects on levels of stress in the population	Will decrease levels of stress in the population
1	2	3	4


2. Culture			
Will decrease the opportunity for people to learn about or participate in cultural practices and traditions	Do not know the effect on opportunity to learn about or participate in cultural practices and traditions	Will have no effect on opportunity to learn about or participate in cultural practices and traditions	Will increase opportunity to learn about or participate in cultural practices and traditions.
1	2	3	4

3. Physical exercise			
Will discourage physical exercise	Not sure if it will discourage physical exercise	Will not discourage physical exercise	Will encourage physical exercise
1	2	3	4

САНАЛ 2: Шүүлтүүрийн шинжилгээний аргачлал буюу *filtration analysis (ME12)*. Энэхүү аргачлал нь үндэсний болон салбарын, аймаг орон нутгийн түвшин хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн баримт бичгүүдэд Монголын нөхцөлд тодорхойлсон Ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтээр чанарын шинжилгээ хийж, Ногоон хөгжлийн бодлоготой нийцтэй байдлын үнэлгээ хийх судалгааны ажлын хүрээнд боловсруулсан.

Хэрэглээ: Энэхүү хэрэгсэл нь бодлогыг зорилт, арга хэмжээг ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтээр шүүж гурав ангилдаг: (i) нийцтэй (ii) хамааралгүй, (iii) орхигдуулсан бөгөөд бодлогын баримт бичгийг зорилтуудын түвшинд төдийгүй бүхэлд нь хэрхэн сайжруулах талаар арга замыг харуулж чадна. Гэсэн хэдий ч бодлогын баримт бичгийг батлах эсэх талаар шийдвэр гаргах ямар нэгэн босго байхгүй.

Давуу тал:	Сул тал:
<ul style="list-style-type: none"> • Бүс нутгийн түвшинд, ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтээр Монгол Улсад туршиж үзсэн • Зорилтуудын түвшинд бодлогыг шинжлэх боломжтой • Бодлогын зорилтуудад тусгагдаагүй байгаль орчны асуудлыг илрүүлэх боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Бодлогын баримт бичгийг батлах эсэх талаар шийдвэр гаргах ямар нэгэн босго утга байхгүй • Бодлогын төсөлд туссан зорилтуудын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг харуулахгүй.



САНАЛ 3: Бутаны чанарын шинжилгээ + Шүүлтүүрийн шинжилгээ. Энэ арга хэрэгсэлд дээрх арга хэрэгслүүдийн дутагдлыг арилгах, давуу талыг авч үлдэхийг хичээсэн.

Хэрэглээ: Энэ хэрэгсэлд Бутаны арга хэрэгслийн онооны системийг ашиглах бөгөөд ТХЗ-ын холбогдох зорилтуудыг асуулга хэлбэрт оруулж шалгуур болгон асууна. Бодлогын баримт бичгийг батлах эсэх талаар шийдвэр гаргах босго утга байж болох бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөөгүй байдлаар тодорхойлж болно.

Давуу тал:	Сул тал:
<ul style="list-style-type: none"> • Бодлогын баримт бичгийг батлах эсэх талаар шийдвэр гаргах ямар нэгэн босго утгатай • Орхигдуулсан ТХЗ-ыг харуулах боломжтой • Бодлогын хэдэн зорилт тухайн ТХЗ-ын зорилтод чиглэж байгааг харуулах боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Бодлогын төслийн аль зорилтуудад өөрчлөлт хийх шаардлагатайг хэлэх боломжгүй • Өмнөх саналуудтай харьцуулахад илүү төвөгтэй болно

Байгаль орчны зорилтуудыг уялдуулсан байдалд өгөх оноо							
			Сөрөг	Мэдэхгүй	Нөлөөгүй	Эерэг	
№	ТХЗ		1	2	3	4	
1	2.4						x_1
2	2.5						
3	3.9						
...					
N					
НИЙТ							

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Banerjee, Onil & Cicowiez, Martin & Horridge, Jonathan & Vargas, Renato. (2019). Evaluating Synergies and Trade-Offs in Achieving the SDGs of Zero Hunger and Clean Water and Sanitation: An Application of The IEEM Platform to Guatemala. *Ecological Economics*. 161. 280-291. 10.1016/j.ecolecon.2019.04.003.
- Biggeri, Mario & Clark, David A. & Ferrannini, Andrea & Mauro, Vincenzo, 2019. "Tracking The SDGs in an Integrated' Manner: A Proposal for a New Index to Capture Synergies and Trade-Offs Between and within Goals," *World Development*, Elsevier, vol. 122(C), pages 628-647. Cambridge Conservation Initiative. (2019). SDG Tool-Version 0.6-Revision 30. <https://sdgtool.com/>
- Barquet, K., Trimmer, C., Stuessen, A., Joyce, B. and Jambal, D. (2019). Piloting the SDG Synergies Approach in Mongolia. Stockholm Environment Institute, Stockholm.
- E. Kemp-Benedict (2014). Shifting to a green economy: Lock-in, path dependence, and policy options. SEI Working Paper 2014-08.
- Eric Kemp-Benedict. (2018). Dematerialization, decoupling, and productivity change. *Ecological Economics*, 150 (2018), 204–216.
- PAGE. (2014). Mongolia's transition to a Green Economy: A stocktaking report. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр.
- Persson, Åsa & Runhaar, Hens & Karlsson-Vinkhuyzen, Sylvia & Mullally, Gerard & Russel, Duncan & Widmer, Alexander. (2018). Editorial: Environmental Policy Integration: Taking stock of policy practice in different contexts. *Environmental Science & Policy*. 85. 113-115. 10.1016/j.envsci.2018.03.029.
- Vanham, Davy & Leip, Adrian & Galli, Alessandro & Kastner, Thomas & Bruckner, Martin & Uwizeye, Aimable & Dijk, Kimo & Ercin, Ertug & Dalin, Carole & Brandão, Miguel & Bastianoni, Simone & Leach, Allison & Chapagain, Ashok & Velde, Marijn & Sala, Serenella & Pant, Rana & Mancini, Lucia & Monforti, Fabio & Hoekstra, Arjen. (2019). Environmental footprint family to address local to planetary sustainability and deliver on the SDGs. *Science of The Total Environment*. 693. 133642. 10.1016/j.scitotenv.2019.133642.
- Villeneuve, C., Tremblay, D., Riffon, O., Lanmafankpotin, G., & Bouchard, S. (2017). A Systemic Tool and Process for Sustainability Assessment. *Sustainability*. Sustainability 2017.
- Weitz, N. C. (2017). Towards systemic and contextual priority setting for implementing the 2030 Agenda. *Sustainability Science* 13, 531–548.
- Wingard, James & Pascual Carnicero, Maria & Bhattarchaya, Gitanjali & Rude, Amanda & Houle, Abigail & Conaboy, Nathan. (2018). Silent Steppe II: Mongolia's Wildlife Trade Crisis, Ten Years Later. 10.13140/RG.2.2.18957.03049.
- АХБ. (2018 7 дугаар сар). Strengthening the Environmental Dimensions of the Sustainable Development Goals in Asia and The Pacific: Knowledge-sharing workshop proceedings. Манила хот.
- АХБ. (2018). Asian Development Outlook. Манила: Азийн хөгжлийн банк.
- АХБ. (2019a). Strengthening the Environmental Dimensions of the Sustainable Development Goals in Asia and the Pacific: A Stocktake of National Response to Sustainable Development Goals 12,14 and 15. Манила хот.
- АХБ. (2019b). Strengthening the Environmental Dimensions of the Sustainable Development Goals in Asia and the Pacific: Tool Compendium. Манила.
- АХБ. (2019c). Asian Development Outlook 2019 Update. Fostering Growth and Inclusion in Asia's

Cities. Манила.

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2010 оны 5 дугаар сарын 27). Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-156 дугаар тушаалын хавсралт.
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. (2013 оны 5 дугаар сарын 16). Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-156 тоот тушаалын хавсралт.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар. (2012). Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж.
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. (2013 оны 3 дугаар сарын 1). Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн журам. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-366 дугаар тушаал.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2009 оны 9 дүгээр сарын 2). Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 31 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2011 оны 10 дугаар сарын 24). Ургамлын нөхөн төлбөрийг төлүүлэх журам, аргачлал. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-354 дүгээр тушаал.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2016 оны 12 дугаар сарын 13). Ойгоос мод бэлтгэх журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/133 дугаар тушаал.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2017 оны 4 дүгээр сарын 3). Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт олгох, хяналт тавих журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/75 дугаар тушаал.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2018 оны 1 дүгээр сарын 30). Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/18 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2018 оны 3 дугаар сарын 13). Сав газрын талуудын оролцооны зөвлөл байгуулах, ажиллах журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-57 тоот тушаалын хавсралт.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2018 оны 11 дүгээр сарын 12). Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/428 дугаар тушаалын хавсралт.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам. (2017 оны 8 дугаар сарын 17). Бичил уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх аргачлал. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан А/2269, А/182 тоот тушаалын 1 дүгээр хавсралт.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2019 оны 10 дугаар сарын 29). Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 дугаар тушаалын хавсралт.
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Барилга хот байгуулалтын яам. (2015 оны 6 дугаар сарын 5). Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан А/230/127 дугаар тушаал.
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Сангийн яам. (2015 оны 3 дугаар сарын 31). Ойг хамгаалах, тарьц, суулгац ургуулах ажлыг урамшуулах журам. Байгаль

- орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан А-140/63 дугаар тушаал.
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. (2014 оны 4 дүгээр сарын 10). Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт.
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. (2014 оны 1 дүгээр сарын 6). Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-03 тоот тушаалын хавсралт.
- Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам. (2013 оны 11 дүгээр сарын 16). Засгийн газрын 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт.
- Байгаль орчны яам. (2008 оны 6 дугаар сарын 3). Ашигт малтмал олборлох, боловсруулах явцад үүсэх хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, экологийн хохирол тооцох аргачлал батлах тухай. Байгаль орчны сайдын 207 дугаар тушаалын хавсралт.
- Байгаль орчны яам, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын яам. (1997 оны 10 дугаар сарын 21). Унд ахуйн зориулалттай усны объектын усны чанарын норм, шаардлага. Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 143/А/352 дугаар тушаалын 2 дугаар хавсралт.
- Байгаль орчны яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам. (1997 оны 10 дугаар сарын 21). Унд ахуйн ус ашиглалтын зориулалттай усны объектод байх хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 143/А/352 дугаар тушаалын 5 дугаар хавсралт.
- Байгаль орчны яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам. (1997 оны 10 дугаар сарын 21). Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм. Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 1997 оны 143/А/352 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт.
- Байгаль орчны яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам. (1997 оны 10 дугаар сарын 21). Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм. Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 143/А/352 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт.
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам. (2018 оны 3 дугаар сарын 27). "Тогтвортой хөгжил-Дээд боловсрол" бодлогын зөвлөмж. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 1а/2718 дугаар албан бичиг.
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэнд, спортын яам, Сангийн яам. (2015 оны 6 дугаар сарын 29). Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан А/253/251/173 дугаар тушаал.
- Бутан ба Үндэсний аз жаргал судлалын төв. (2019). www.grossnationalhappiness.com. <http://www.grossnationalhappiness.com/gnh-policy-and-project-screening-tools/>
- Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон Өнсалагийн их сургууль, Боловсролын хамтын ажиллагааны байгууллага (IZB). (2017). Education for Sustainable Development-Annual Report. Улаанбаатар: Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг.
- Дэлхийн банк. (2006). Байгаль орчны менежментийг сайжруулах аргачилсан зөвлөмж. Улаанбаатар: "Байгаль орчны менежментийн чадавхыг үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх нь" IDG Grant TF 051255 төслийн зөвлөхийн тайлан.
- Дэлхийн банк. (2017 оны 6 дугаар сар). Улаанбаатар хотын гэр хорооллын өрхүүдийн ариун цэврийн байгууламжийг сайжруулахад тулгарч буй асуудлууд ба боломжууд. Монгол Улс: Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах нь.

- М.Алтанбагана, Б. Т. (2015). Эмзэг байдлын үнэлгээнд тулгуурлан Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх нь. Монгол орны бэлчээрийн сэргэн хөгжих чадавхыг бэхжүүлэх нь сэдэвт салбар хөрвөсөн олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 195-200.
- М.Алтанбагана, Б.Хэрлэнбаяр, Б.Сувданцэцэг, Х.Номинболор. (2015). "Ногоон хөгжлийн тэргүүлэх 5 аймгийн сумдын байгаль орчин, нийгмийн эмзэг байдлын судалгаа хийж, бодлогын санал зөвлөмж боловсруулах" бодлогын судалгааны тайлан. Улаанбаатар: Үндэсний хөгжлийн хүрээлэн.
- Монгол Улсын Засгийн газар. (2003 оны 7 дугаар сарын 15). Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам. Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2003 оны 7 дугаар сарын 15). Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам. Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2003 оны 2 дугаар сарын 7). Газар зохион байгуулалт хийх журам. Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2003 оны 2 дугаар сарын 7). Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам. Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2006 оны 7 дугаар сарын 19). Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам. Засгийн газрын 2006 оны 176 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2010 оны 3 дугаар сарын 10). Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 59 дүгээр тогтоолын хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2011 оны 10 дугаар сарын 26). Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2013 оны 2 дугаар сарын 16). Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам. Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2013 оны 11 дүгээр сарын 16). Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам. Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2013 оны 2 дугаар сарын 16). Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам. Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2014 оны 2 дугаар сарын 14). Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам. Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2016 оны 5 дугаар сарын 9). Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам. Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2017 оны 9 дүгээр сарын 27). Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам. Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолын хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2018 оны 6 дугаар сарын 20). Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал. Засгийн газрын 2018 оны 181 дүгээр тогтоолын хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2018 оны 12 дугаар сарын 26). Зөвшөөрсөн хэмжээнээс

- илүү ашигласан усны төлбөр тооцох журам. Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолын хавсралт.
- Монгол Улсын Засгийн газар. (2019). Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт. Улаанбаатар хот.
- Монгол Улсын Их Хурал. (2014 оны 6 дугаар сарын 13). Ногоон хөгжлийн бодлого. Ногоон хөгжлийн бодлого батлах тухай. Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт.
- Монгол Улсын Их Хурал. (2015 оны 11 дүгээр сарын 26). Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль.
- Монгол Улсын Их Хурал. (2016 оны 2 дугаар сарын 5). Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт.
- Монголын банкны холбоо. (2014). Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд.
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим. (2013 оны 5 дугаар сарын 22). Ногоон оффисын менежментийн аргачлал. Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын даргын 142 тоот тушаал.
- МТҮП-ийн Инкубатор, бизнес хөгжүүлэлтийн төв. (2016). Монгол инновац" – Бодлогын Зөвлөмж. Улаанбаатар хот.
- НҮБ-ын ЭЗК. (2018). Байгаль орчны гүйцэтгэлийн тайлан. Нью Йорк, Женев: Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ, Цуврал No.49.
- Нэгдсэн Үндэстний Байгууллага. (2018). Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөв байдлын тайлан. Улаанбаатар хот.
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр. (2009). Mainstreaming Poverty-Environment Linkages into Development Planning: a Handbook for Practitioners. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр Ядуурал-байгаль орчны санаачилга.
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр. (2015). Mainstreaming Environment and Climate for Poverty Reduction and Sustainable Development: A Handbook to Strengthen Planning and Budgeting Processes. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр Ядуурал-байгаль орчны санаачилга.
- Стандарт, хэмжил зүйн газар. (2009 оны 12 дугаар сарын 24). Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага. MNS 6043:2009. Монгол Улсын стандарт.
- Стандарт, хэмжил зүйн газар. (2015 оны 12 дугаар сарын 24). Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. MNS 4943:2015. Монгол Улсын стандарт. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 50 дугаар тогтоол.
- Стандарт, хэмжил зүйн газар. (2015 оны 12 дугаар сарын 24). Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага. MNS 5924 : 2015. Монгол Улсын стандарт. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 59 дүгээр тогтоол.
- Үндэсний статистикийн хороо. (2019 оны 9 дүгээр сарын 16). Байгаль орчны үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал.
- Үндэсний статистикийн хороо. (2017 оны 7 дугаар сарын 3). Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, түүнийг тооцох аргачлал.